

Сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийг дэмжих нь. Зааварлагчдад зориулсан гарын авлага



© IMS, Réseau Liberté, M&DG

Сонгуулийн үеэр хэвлэл мэдээлэлийг дэмжих нь. Зааварлагчдад зориулсан гарын авлага

Энэхүү гарын авлагын зохиогчийн эрхийг “Интернешнл медиа саппорт” (International Media Support), “Медиа энд демокраси групп” (Media&Democracy Group), “Сүлжээ-эрх чөлөө” (Réseau Liberté) байгууллагууд эзэмшинэ.

Анхны хэвлэл 2006



International Media Support
Wilders Plads 8A 1403
Copenhagen K
Denmark
Утас: +45 32698989
Факс: +45 32698994
Имэйл: i-m-s@i-m-s.dk
Цахим хуудас: www.i-m-s.dk



Media&Democracy Group
500- 200 Cambie St.
Vancouver
Canada V6B 2M9
Утас: 1-902-422-1271 Ext. 164
Имэйл: info@mediaanddemocracy.ca
Цахим хуудас: www.mediaanddemocracy.ca



Réseau Liberté
235A Fleury Ouest
Montréal, Quidbec
Canada H3L 1T8
Утас: +1 514 858-7448
Факс: +1 514 858-1624
Имэйл: info@reseauliberte.com
Цахим хуудас: www.reseauliberte.com

Боловсруулж хэвлэлд бэлдсэн:

Torben Brandt, Thomas Hughes and Finn Rasmussen (*IMS*);

Ross Howard and Derek Quinn (*Media&Democracy Group*);

Réal Barnabé, Paul Breton and Jacquelin Тиймаке (*Réseau Liberté*).

Агуулга

1. Оршил	4
2. Улс орны нөхцөл байдал	6
2.1 Улс төрийн суурь мэдээлэл	6
2.2 Хэвлэл мэдээллийн орчин	7
2.3 Сонгуулийн орчин	9
3. Зааварчилгааны арга зүй	12
4. Сонгууль сурвалжлах арга хэрэглүүр	15
4.1 Тайлбар зурвас	15
4.2 Сонгууль сурвалжлах хэрэглүүр	16
4.3 Сонгууль сурвалжлах олон улсын хэм хэмжээнүүд	26
4.4 Суурь сэтгүүл зүй	28
4.4.1. Мэдээ бэлтгэхдээ тунгаан бодох нь, ур чадвар	29
4.4.2. Арга барил	31
4.4.3. Зохион байгуулалт ба арга барил	35
4.5 Сонгуулийн сурвалжлагыг төлөвлөх нь	37
5. Практик мэдээлэл	41
6. Эх сурвалж: интернэтээс хэрэгцээт зүйлээ нь олох нь	44
7. Редакцийн сануулга	46
8. Зааварлагчдад зориулсан асуулга	47

1. Оршил

Энэхүү гарын авлага нь сонгууль сурвалжлах сэтгүүлчдийн ур чадварыг дээшлүүлэх шинэ аргын талаар өгүүлсэн бөгөөд сонгуулийн талаар, мөн мэдээ, нийтлэл бичих арга техник болоод түүний төлөө үүрэх хариуцлагын талаар өгүүлнэ. Гарын авлагыг сонгууль, санал хураалтын үеэр дэлхий нийтээр өргөн цар хүрээнд ашиглаж болох боловч нэн тэргүүнд улс төрийн байдал тогтвор муутай орнууд буюу ардчилалд шилжиж буй орнуудын сэтгүүлчдийг зааварчлах хэрэгсэл болгох зорилгоор тусгайлан боловсруулсан юм.

Юуны өмнө, тухайн гарын авлагыг бидний нэрлэдгээр “зааварлагч” хэмээх ур чадвар дээшлүүлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлдэг тэдгээр хүмүүст зориулсан гэдгийг та бүхэн харах болно. Энэ гарын авлага нь зааварчилгаа буюу сургалт явуулдаг хүмүүст зориулагдсан хэрэгсэл билээ.

Сэтгүүлч, сурвалжлагч, эрхлэгч болон ХМХ-ийн удирдлага ч мөн адил хэвлэл мэдээллээр сонгууль хэрхэн сурвалжлах талаар судалж, ур чадвар, дадлага туршлагаа дээшлүүлэх боломжтой ажээ. Тийм ч учраас энд өгүүлэгдэж буй мэдээллийг аль болох өргөн цар хүрээнд түгээн тарааж, сэтгүүлчийн хөтөч болгоход ашиглах нь зүйтэй юм.

Тус гарын авлагыг (Riseau Liberté) байгууллагын хэрэгжүүлж буй сэтгүүл зүйн хөгжлийн хөтөлбөрийн үр дүнд бий боловсруулсан бөгөөд Канадын Олон улсын Хөгжлийн CIDA агентлаг санхүүжүүлсэн юм. Гаитийн хэвлэл мэдээллийг дэмжих зорилготой тус хөтөлбөр нь CBC/Канадын радиогийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн ажилтан бэлтгэх хүрээлэн болон Монреаль хотноо төвтэй “Alternatives” ТББ гэсэн түнштэй юм.

2005 – 2006 онд Гаитид зохион байгуулагдсан сонгууль сурвалжлах сэтгүүлчдийг бэлтгэх хэд хэдэн уламжлалт сургалтын дараа “Сүлжээ – эрх чөлөө” байгууллага нь өөр хандлага, өөр арга замыг эрэлхийлсэн юм. Тэд, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудад ажлын байрнаас гадуур сургалт семинар хийхийн оронд тэдний өдөр тутмын үйл ажиллагааны үеэр хамтарч ажиллахыг илүүд үзсэн байна.

Уг шинэ хандлагыг сайтар судалсан бөгөөд “зааварчилгаа” гэж нэрлэх хэвлэл мэдээллийн хэрэгслийн (ХМХ) үйл ажиллагааг сайжруулах шинэ бүтэц бүхий аргачлалыг боловсруулах үндэс нь болсон билээ. Ингээд зааварлагчдад зориулсан хэвлэл мэдээллээр сонгууль сурвалжлах арга зүйн гарын авлага бэлэн боллоо.

Гаитийн туршлага бүхий гарын авлагыг Монреалийн “Сүлжээ – эрх чөлөө” байгууллага, Копенгагенд байрлах “Интернешнл медиа саппорт” (IMS) болон “Медиа энд демокраси групп” (M&DG) байгууллагуудтай хамтарч боловсруулсан юм. Эдгээр хоёр байгууллага нь агуулга боловсруулахад чухал хувь нэмэр оруулсан билээ. “Сүлжээ – эрх чөлөө” байгууллагын нэгэн адил дээрх хоёр байгууллага нь дэлхий нийтээр хэвлэлийн эрх чөлөөг хөхиүлэн дэмжиж, зөрчилдөөний улмаас хохирол амсч буй улс орнуудын хэлэл мэдээлэл, сэтгүүлчдэд дэмжлэг үзүүлдэг.

Гаитийн туршлагын ололт амжилтыг үндэслэн сонгууль сурвалжлахад дэлхий нийтээр ашиглахуйц зааварчилгааны шинэ гарын авлага боловсруулах шийдвэрт хүрчээ. Үүнд аливаа улс орны сонгуулийн талаар мэдээ сурвалжлага бэлтгэж буй сэтгүүлчдийг зааварчлах үндсэн материал оруулахдаа ардчилалд шилжиж буй орнуудад онцгой анхаарал хандуулсан байна. Гарын авлагын агуулгад: зааварчилгаа хэмээх ойлголтын тодорхойлолтыг түүний зорилго, арга барилын хамтаар, мөн улс орон, түүний сонгуулийн үйл явц болоод улс төрийн нөхцөл байдлын талаар зааварлагчдын мэдэхийг эрмэлзэж буй зүйлсийн талаар тодруулга тайлбар, сонгуулийн үеэр ХМХ-ийн үйл ажиллагааны үндсэн төлөв байдал болоод өдөр тутмын амьдралын практик мэдээлэл, зааварчилгаа явуулах бэлтгэл хэрхэн базаах талаар өгүүлэх болно.

Тухайн гарын авлагын агуулгад радио, телевиз, сонин, сэтгүүл болоод интернэтийн талаар бичсэнээр ерөнхий шинжтэй юм. Харин Гаитийн гарын авлага нь зөвхөн радио, телевизэд чиглэгджээ. Үүний зэрэгцээ, гарын авлагын “Арга хэрэглүүрүүд” бүлэгт чөлөөт, шударга сонгуулийн олон улсын хэм хэмжээнүүд, сонгууль сурвалжлах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, интернэт ашиглах заавар, мөн хэрэг болохуйц цахим хуудсуудын талаар нэмэлт мэдээлэл оруулсан байна. Гэсэн ч, уг гарын авлагыг ашиглах зааварлагчид нь өөрийн үйл ажиллагаа явуулах гэж буй улс орны талаар мэдээлэл цуглуулах шаардлагатай гэдгийг энд онцлох нь зүйтэй болов уу. Гарын авлагад цуглуулах мэдээллийн төрлийг мөн багтаалаа.

Эцэст нь тэмдэглэхэд, гарын авлагын төгсөлд буй асуулгууд нь таны зааварчилгааны үйл ажиллагааг үнэлж дүгнэхэд чухал үүрэгтэй. Мөн уг гарын авлагыг бэлтгэсэн байгууллагуудад ч ашиг тусаа өгч болно. Бид хийсэн ажлаа эргэн харж, засч сайжруулах зорилгоор хэрэглэгчдээсээ санал сэтгэгдэлийг нь хүлээн авах хүсэлтэй билээ.

Уг гарын авлага нь гурван гол оролцогчдын нягт хамтын ажиллагааны үр дүн юм. Копенгагены “Интернешнл медиа саппорт” (IMS) байгууллага нь санаа хөгжүүлэх болон зааварчилгааны гарын авлагын үзэл баримтлал, арга зүйг боловсруулахад тусалсан бөгөөд хэвлэлтийн бүхий л үйл явцыг хянаж байв. Монреалийн “Сүлжээ – эрх чөлөө” (Rйseau Libertй) байгууллага нь “Оршил”, “Зааварчилгааны арга зүй”, “Гаитид ажилласан туршлага” бүлгүүд дээр ажиллав. Ванкуверт үйл ажиллагаа явуулж буй “Медиа энд демокраси групп” (M&DG) байгууллага нь “Тухайн улс орны байдал”, “Хэвлэл мэдээллийн орчин”, “Сонгууль явуулах нөхцөл”, “Сонгууль сурвалжлах хэрэглүүр”, “Практик мэдээлэл” бүлгүүд болон интернетийг судалгааны хэрэгсэл болгон ашиглах талаар өгүүлсэн бүлгийг боловсруулав. СВС/Канадын радиогийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн ажилтан бэлтгэх хүрээлэн нь сонгууль сурвалжлах үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар мэдээлэл бэлтгэж, гарын авлага боловсруулах үйл явцад үнэлж баршгүй хувь нэмэр оруулав.

Үүнээс гадна, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО) дэмжлэг тусалцаа үзүүлсэнд талархал илэрхийлж байна.

Гарын авлага таны таалалд нийцнэ хэмээн найдаж, ажлын өндөр амжилт хүсье.

2. Улс орны нөхцөл байдал: ажлаа эхлэхийн өмнө

Тойм

Сургагч, зааварлагчид ажлаа хийж буй сэтгүүлчдийн нэгэн адил таньж мэдэхгүй улс оронд очихын өмнө эрчимтэй судалгаа хийхийг хүсэх нь мэдээж. Тухайн улс орны талаар ерөнхий ойлголттой болох нь маш чухал билээ. Ийм ойлголтонд улс орны хүн ам зүй, түүх соёл, мөн улс төрийн сүүлийн үеийн болон өнөөгийн нөхцөл байдал болоод хэвлэл мэдээллийн орчин багтдаг. Тухайн сонгуулийн нөхцөл байдлыг тодорхойлоход эдгээр мэдээлэл тун чухал. Мөн та сонгууль явуулах журмын талаар мэдэхийг эрмэлзэнэ.

Өнөөгийн интернетээс улс орнуудын хүн ам, эдийн засгийн байдал, эрүүл мэндийн стандартаас өгсүүлээд хүн амын боловсролын түвшин зэрэг бүх төрлийн мэдээлэл агуулсан олон тооны лавлах, цахим хуудсууд олох боломжтой. Тухайн лавлахыг судалж үзэхдээ, хүн амын насжилт ба сонгуулийн эрх бүхий иргэдийн тоо, иргэдийн суурь боловсрол эзэмшилтийн байдал, төрөл бүрийн үндэстэн угсаатны бүлгүүд, шашин шүтлэг, хэл соёл, мөн хотын болон хөдөөгийн хүн амын тухай мэдээ баримтууд дээр анхаарлаа хандуулах нь зүйтэй юм. Эдгээр үзүүлэлт нь сонгогчдын чухал бүлгүүд, сонгогчдын боловсролын асуудлууд болоод анхаарлын гадна үлдэх магадлалтай бүс нутаг, асуудлуудыг тодорхойлдог учраас хэвлэл мэдээллээр сонгуулийн кампанит ажлыг сурвалжлахад харгалзан үзэх шаардлагатай юм.

Үндсэн мэдээлэл, цахим хуудсуудыг дурын цахим хайлтын системээр “улс орны лавлах” гэсэн түлхүүр үгээр хайж, олох боломжтой. Эдгээрийн тоонд “BBC World Country Profiles”, “IRIN, AllAfrica.com”, “Oneworld.net”, “the Lonely Planet” жуулчдын хөтөч, зөрчилдөөний дараахь улс орнуудын тухай интернетийн эх сурвалж бүхий INCORE лавлах, тэр ч байтугай CIA World Factbook зэрэг эх сурвалжууд багтана. Үүнээс гадна олон тооны бусад эх сурвалж байдаг.

Зааварлагчид тухайн улс орны бяцхан хөтөч, мөн газрын зураг биедээ авч явах нь зүйтэй. Учир нь орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудад эдгээр материал байхгүй байж мэднэ. Нутгийн иргэд нь өдөөн хатгасан болон доромжилсонд тооцохуйц мэдээ, мэдээллийг бүү авч яваарай.

2.1. Улс төрийн суурь мэдээлэл

Улс төрийн нөхцөл байдал

Сонгуульд олон нийтийн дэмжлэг, эрх мэдлийн төлөө өрсөлдөгч улс төрийн намууд оролцдог учраас тухайн улс орны улс төрийн түүхийн талаар гол баримтуудыг мэдэх нь чухал билээ. Эдгээрт намуудын кампанит ажилд сонгогчдын хэрхэн хүлээж авахаас шалтгаалж буй онцгой чухал үүрэгтэй баримт сэлт буюу үйл явдал байж болно. Улс орны тусгаар тогтнолоо тунхагласан он, сар, өдөр, дотоодын болон хил хоорондын зөрчилдөөн, кампанит ажлын асуудал эсхүл сэдэв болж болох түүхэн баатрууд болон хорон муу санаатнуудын талаар мэдэж байвал зохилтой.

Судлууштай бусад хүчин зүйлсийн хувьд, өмнөх засгийн газруудын дэглэм, цэрэг арми, бусад хүчний үүрэг оролцоо, эсвэл өмнөх төр засгийн эрх барих үеийн гадаад улс

орнуудын хөндлөнгийн оролцоо зэрэг болно. Түүнчлэн, ерөнхийлөгчийн засаглал, парламентын ардчилал, хаант засаг зэрэг төр, засгийн болон улс төрийн тогтолцоог олж мэдэх шаардлагатай. Мөн, ойрын үед явагдсан орон нутгийн сонгуулийн төлөв байдлыг ойлгож мэдэх нь тустай.

Улс төрийн өнөөгийн нөхцөл байдал

Улс төрийн өнөөгийн нөхцөл байдал буюу сонгуулийн шууд орчны талаар мэдээлэлтэй байх нь зааварлагчдын мэдвэл зохих чухал зүйл юм. Өмнөх төр засгийн эрх барих хугацаанд ямар гол асуудлууд үүсч байсан, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэж байсан болоод тэдгээр нь энэ сонгууль явагдах шалтгаан болсон эсэхийг олж мэдээрэй. Зааварлагчид улс төрийн гол нам, эвслийн нэр, тэдгээрийн тэргүүлэх үзэл баримтлал, удирдагчид, мөн харьцангуй хүч, нэр хүндийнх нь талаар мэдэх шаардлагатай. Энэ мэдээлэл нь сонгууль сурвалжлах ажил тэнцвэртэй явагдаж байгаа эсэхийг дүгнэхэд зааварлагчдад хэрэг болно. Анхааралдаа авах бусад хүчин зүйлсийн тоонд, ардчиллын хөгжлийн түвшин, олон нийтийн аж амьдралд иргэний нийгмийн үзүүлэх нөлөө, оролцоо, шүүхийн байгууллага, гүйцэтгэх засаглалын хууль ёс, хүний эрхийг дээдлэх, авлига болон хууль зөрчиж буй үйлдлийн түвшин, мөн өвөрмөц бүлгүүдийн хоорондын улс төр, эдийн засгийн тэгш бус байдал хамаарна. Үүнээс гадна, хэвлэл мэдээлэл болон улс орны тойм, түүнчлэн “Хьюман райтс уотч” (Human Rights Watch), “Эмнести Интернэшнл”, “Фрийдом Хаус” (Freedom House), “Олон улсын хямралын асуудал хариуцсан бүлэг” байгууллагууд, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг үндэслэж дээрх дүгнэлтэнд хүрч болно. Зааварлагчид нь сонгуулийн мониторинг явуулдаг олон улсын бүлэглэлүүдийн тайлан болон ажилтнуудаас ашигтай бөгөөд баялаг мэдээлэл авах боломжтой.

2.2. Хэвлэл мэдээллийн орчин

Хэвлэлийн эрх чөлөө болон түүний зохицуулалтын талаар тухайн улс орны баримтлах зарчмыг тодорхойлох нь нэн тэргүүний зорилт билээ. Үүний дараа, зааварлагчид эдгээр эрх чөлөө, зохицуулалтын бодит байдлын хэрэгжилтийг тодорхойлох нь зүйтэй. Зарим улс оронд хэвлэлийн эрх чөлөөний өргөн хүрээний хамгаалалтыг Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор баталгаажуулсан байх боловч эдгээр эрх чөлөөг эрх баригчид эсвэл сэтгүүлчид өөрсдөө зөрчих буюу үл тоомсорлох явдал өдөр тутам тохиолдсоор байдаг.

Хэвлэлийн зохицуулалт

Хэвлэлийн зохицуулалтад хамаарах чухал асуудлуудаас дараахийг авч үзэх шаардлагатай.

Үүнд:

- Үндсэн хуулиар баталгаажуулсан хэвлэлийн эрх чөлөөний тухай зүйл заалт бусад хууль тогтоомжид байдаг уу? Шүүх байгууллагын зүгээс эрх баригчид эсвэл бусад талуудын дарамт шахалт, сүрдүүлэг заналхийллийн эсрэг эрчимтэй хамгаалалт үзүүлдэг үү?
- Хэвлэлийн зохицуулалтын байгууллагуудын (хэвлэлийн консул болон радио, телевизийг зохицуулах байгууллага) эрх мэдлийн түвшин ямар байна вэ? Тэдгээр нь төр засаг, авлигаас хараат бус байж чаддаг уу? Хариуцлага алдсан хэвлэл мэдээллийн хэрэгсэлд сахилгын зохих шийтгэл ногдуулдаг уу?

- Агуулгын хязгаарлалт. Хэвлэлийн мэдээ, нийтлэл буюу түүний илэрхийлж буй санаа бодлыг цензурддэг хуулийн заалт байдаг уу? Эдгээр хязгаарлалтыг хэн тогтоодог вэ? Шүүхэд давж заалдах боломж бий юу? Үзэн ядалт өдөөсөн мэдэгдлийг зохицуулах хуулийн заалт байдаг уу? Эрх баригчдыг шүүмжилсэн нийтлэл хэвлүүлэхгүй байхын тулд гүтгэлэг, доромжлолын гэмт хэргийн зүйл заалтыг бодит амьдрал дээр ашигладаг уу?
- Интернетийн хүртээмжийг өргөн цар хүрээгээр хангаж чадсан уу? Интернетийг зохицуулах зохицуулалт эсвэл цензур оршиж байна уу? Интернетийн үзүүлэх нөлөө хэр вэ?
- Өмчлөлийн хязгаарлалт. ХМХ-ийн өмчлөл нь төр засаг, хууль тогтоомж эсвэл чөлөөт зах зээлийн өрсөлдөөний алинаар зохицуулагддаг вэ?
- Сэтгүүлчдийн бүртгэл/магадлан итгэмжлэл. Сэтгүүлч хүн ямар байх ёстойг тодорхойлсон хууль тогтоомж байдаг уу? Тухайн хуулийг хэрэгжүүлэгч этгээд нь хэн бэ? Тухайн хуулийг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахад ашиглах тохиолдол бий юу?
- Өргөн нэвтрүүлгийн ХМХ-үүд хэрхэн зохицуулагддаг вэ? Тусгай зөвшөөрөл шударга үндсэн дээр олгогддог уу? Олон нийтийн эсвэл төр засгийн мэдлийн өргөн нэвтрүүлэгт хувийн өмчит өргөн нэвтрүүлгээс ялгавартай ханддаг уу?
- Мэдээллийн хүртээмжийн талаар хууль тогтоомж байдаг уу? Тухайн хуулиуд хэр үр дүнтэй байна вэ? Тухайн хуулиудад нууцын тухай хууль, улс төрийн оролцоо буюу хүнд суртлын саад тоггор зэрэг нь хязгаарлалт болдог уу?

Хэвлэл мэдээллийн салбар

Зааварлагчид ХМХ-ийн бүтэц болоод практик аргуудыг судлах нь зүйтэй. Үүнд:

- Төрийн хяналтанд байдаг болон хувийн өмчит хэвлэмэл болон өргөн нэвтрүүлгийн ХМХ-ийн тоо баримт, хот, хөдөөгийн уншигч, сонсогч, захиалагчдын тоо зэрэг мэдээ, баримт.
- Зохицуулалтын үр ашиг. Тухайн орны ХМХ-үүд Хэвлэл мэдээллийн тухай болон Иргэний хуулийг дагаж мөрддөг үү?
- ХМХ бүрийн хараат бус байдал эсвэл тэдэнд тавих хяналт, алагчлал болон тал тохой татах явдал. Өмчлөгчид болон бусад сонирхогч талууд сэтгүүлчдийг бодит бус, тал тохой татсан мэдээ, нийтлэл бичихийг албадах явдал гардаг уу?
- ХМХ-ийн нөлөө. ХМХ нь бусдын итгэлийг хүлээн, хараат бус хэмээн тооцогддогийн улмаас нэр нөлөөтэй байна уу эсвэл ХМХ-ийг эрх мэдэлтэй талуудын “дуу хоолой” хэмээн үздэг уу? ХМХ нь олон нийтийн санал бодолд хамгийн чухал нөлөө үзүүлэгч мөн үү?

Сэтгүүл зүйн бүлэглэл

Зааварлагчид нь сэтгүүл зүйн бүлэглэлийн талаар ч мөн ойлголттой байх хэрэгтэй.

Үүнд:

- Улс орны сэтгүүл зүйн ихэнх бүлэглэл үнэн зөв, мэдээллийн шударга тэнцвэртэй байдал болон нийтэлж буй материалынхаа төлөө үүрэх нийгмийн хариуцлага зэрэг мэргэжлийн тодорхой хэм хэмжээг дагадаг уу?
- Сэтгүүлчдийн ажиллах нөхцөл, тэдний аюулгүй байдал, мэргэжлийн бэлтгэл, хэрэглэж буй тоног төхөөрөмж, цалин хөлс хийгээд нийгэмд болон ажлын талбар

дээр эзлэх байр суурь нь ямар байгаа вэ? Цалин багатай, сүрдүүлэг дарамтанд байдаг эсвэл бусдын хүндлэлийг хүлээгээгүй сэтгүүлчид амь зуухын тулд хээл хахуульд автах, алагчилсан, тал тохой татсан мэдээ, нийтлэл бэлтгэх, өөрөө өөрсдийгөө цензурдэх магадлал өндөр байдаг.

- Сэтгүүлчдийн нийгэмлэг, холбоо байдаг уу? Тэдгээр нь хараат бус уу эсвэл улс төрийн ашиг сонирхолтой нягт холбоотой юу? Эдгээр байгууллагууд улс төр, олон нийт болон сэтгүүлчдийн хүрээнд нөлөөтэй юу?
- Сэтгүүлчдийг бэлтгэдэг их, дээд сургуулиуд байдаг уу? Зааварлагчид тэднийг дэмжлэг үзүүлэгч эсвэл хамтрагчаар ашиглах боломж бий юу?
- Цөлөгдсөн эсвэл гадуурхагдсан хэвлэл мэдээллийн бүлэглэл байдаг уу? Тэдгээрийн үзэгч, сонсогчдын болон нөлөөллийн хэр хэмжээ ямар вэ? Гадаадын эсвэл өөр бусад орны ХМХ нөлөө үзүүлдэг үү?
- Сэтгүүлчдэд мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах болон бэлтгэл хийх боломж байдаг уу? Тэдгээр сургалтууд хэр үр дүнтэй байдаг вэ? Ур чадвар дээшлүүлэх талаарх өмнөх идэвх санаачлагуудын тайлан бий юу?

Зааварлагчид боломжийнхоо хэрээр өөрсдийн ажиллах газарт хэвлэл мэдээлэлтэй холбоотой дээрх асуудлуудыг харгалзан үзэх нь зүйтэй. Үүнээс гадна, тухайн улс оронтой холбоотой нутгийн хэвлэлийн консулын тайлангууд, мөн “19 дүгээр зүйл”, Олон улсын сэтгүүлчдийн холбоо (IFJ) болон Олон улсын чөлөөт илэрхийллийн сүлжээ (IFEX) зэрэг олон улсын байгууллагуудын тайлан, цахим хуудастай танилцах хэрэгтэй.

Эцэст нь, сонингуудын нөлөө олон нийтийн суурь боловсрол эзэмшилтийн байдлаар хязгаарлагдаж байна уу, эсвэл зөвхөн дээдсийн хүрээний боловч үр нөлөөтэй давхаргад хүрч байна уу; төрийн мэдлийн хэвлэл мэдээлэл хот, хөдөө ижил түвшинд давамгайлж байна уу; радиогийн өргөн нэвтрүүлгийн ток шоу нь улс төрийн мэтгэлцээний хамгийн нөлөө бүхий хэлэлцүүлгийн тоонд багтдаг уу; хувийн радио станцууд хөгжмийн зугаацуулах нэвтрүүлгүүдээрээ алдартай боловч мэдээнд бага цаг зарцуулдаг уу; нутгийн арилжааны бус, жишээлбэл, шашны эсвэл төрийн бус байгууллагын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг ХМХ-үүд нэр, нөлөөтэй юу зэрэг хэвлэл мэдээллийн харьцангуй нөлөөний янз бүрийн асуудлуудыг судалж үзэх нь зүйтэй. Ингэвээс, зааварлагчдын стратеги, түүнтэй хамтран ажиллаж буй сэтгүүлчдийн хандлагад нөлөөлөх боломж бүрдэнэ.

2.3. Сонгуулийн орчин

Чухал асуултууд

Сонгууль сурвалжлах чухал аспектиуд болон чөлөөт, шударга буюу ардчилсан сонгуулийн олон улсын хэм хэмжээнүүд, хэвлэл мэдээллийн үүрэг, мэдээ, нийтлэлийн үнэн зөв байдлыг хэрхэн хангах зэрэг асуудлууд нь уг гарын авлагын “Арга хэрэглүүрүүд” бүлэгт багтсан болно. Гэвч зааварлагчдад өөрсдийн ажиллах сонгуулийн тодорхой орчны талаар аль болох нарийн тодорхой ойлголт шаардлагатай.

Зааварлагчдын мэдвэл зохих зүйлсэд:

- Сонгууль явагдаж байгаа учир шалтгаан. Энэ нь анхны ардчилсан сонгууль мөн үү? Тухайн сонгууль нь төр, засгийн эрх барих хугацаа дууссан учир явагдаж байна уу, эсвэл эрх баригчид төрийн эргэлтийн улмаас огцрох болсон тул явагдаж байна уу? Өмнөх сонгуулиуд тайван замаар, шударга явагдсан уу?

- Ямар ямар асуудлууд хөндөгдөж байна? Бие даан нэр дэвшигчид болон улс төрийн намууд тэдний рейтингийг өсгөнө хэмээн итгэсэн, эсвэл тэдний бодлогын талаар хурц шүүмжлэлээс зайлсхийхийн тулд тодорхой асуудлууд дээр кампанит ажил өрнүүлнэ. Зааварлагчдад нам, эвслүүд улс оронд тулгараад буй ядуурал, ажилгүйдэл, боловсролын хүртээмж, орон сууцны хангамж, амин чухал нөөц болох ус ба цахилгаан, хууль болон хүний эрхийг дээдлэх зэрэг илэрхий чухал асуудлуудад анхаарлаа хандуулж байгаа эсэхийг тодорхойлох шаардлага тулгарна.
- Ямар дүрэм журам үйлчилж байна вэ? Зааварлагчид сонгуультай холбоотой иж бүрэн дүрэм журмуудыг олж мэдэх хэрэгтэй. Эдгээр материалыг ихэвчлэн Сонгуулийн комисс эсвэл сонгуулийн удирдлагын байгууллага эрхлэн гаргадаг. Ихэнх тохиолдолд сонгуулийн дүрэм журмууд чөлөөт, шударга сонгуулийг баталгаажуулдаг юм шиг боловч бодит байдал дээр тэдгээрийн хэрэгжилтийн сул дорой байдал, авлига, сүрдүүлэг, эсвэл төсөв хөрөнгө болоод аюулгүй байдлын хангалт дутагдсанаас үүдэн тийм биш байдаг. Сонгогчдын бүртгэл нь сонгууль хариуцсан байгууллагын үнэнч шударга бөгөөд үр нөлөөний чухал үзүүлэлт болно. Улс төрийн нам, нэр дэвшигчдийн эрхийг хасах нь мөн зөрчилтэй асуудлын нэг байдаг.
- Нэр дэвшигчид гэж хэнийг хэлэх вэ? Зааварлагчид бүх нам, эвслийн талаар тэдгээрийн өмнө явуулж байсан үйл ажиллагаа, өнөөгийн амлалт, санхүүгийн байдал болон гол нам, эвслийн улс төрд эзлэх жин, тэднийг дэмжигчдийн гол бүс нутаг буюу бүлэглэлүүдийн талаар нарийвчилсан мэдээлэл бүхий жагсаалттай байх нь зүйтэй. Зааварлагчид үүнээс гадна, гол нам, эвслийн үзэл суртлын хандлагууд, удирдагчдын нэрсийг мэдсэн байх нь зүйтэй. Учир нь намууд ихэвчлэн кампанит ажил явуулахдаа намын нэрийн өмнөөс бус өөрсдийн удирдагчдын нэрийн өмнөөс явуулдаг.
- Сонгогчид гэж хэнийг хэлэх вэ? Бүх нийтийн санал хураалт явагдаж байгаа эсэх, түүнд оролцоход аливаа тодорхой бүлгүүд, тухайлбал эмэгтэйчүүд, үндэстний цөөнх, нийгмийн давхарга эсвэл бүс нутгаар ялгаварлан гадуурхах, саналыг нь өгүүлэхгүй байх явдал гарч байгаа эсэхийг тогтоох ёстой. Сонгогчдод саналаа өгөх боломж байна уу, эсвэл дарамт, аюулгүй байдал хангалтгүй, ёс заншил, хангалттай мэдээлэлгүй эсвэл оршин суух байршлын онцлогоос үүдээд сонгуульд оролцохгүй байх магадлал хэр байна вэ?
- Олон улсын сонирхол юунд оршиж байна вэ? Тухайн улс оронд сонгууль явагдахад гадны, жишээлбэл НҮБ гэх мэт олон улсын байгууллагын эсвэл бие даасан улс орны дарамт шахалт бүхэлдээ эсвэл хэсэгчлэн нөлөөлсөн үү? Олон улсын болон гадаадын ямар ажиглагчид сонгуулийн үйл явцад мониторинг хийж эсвэл сонгууль явуулахад дэмжлэг үзүүлж байна вэ? Эдгээр нь сонгуулийн кампанит ажлын явцад мэдээллийн чухал эх сурвалжууд болж болно.
- Сонгуулийн хуанли ямар байна вэ? Сургагч нар тодорхой үйл явдал, тухайлбал, нэр дэвшигчдийг тодруулах ба сонгогчдыг бүртгэж дуусах хугацаа, сонгуулийн кампанит ажил дуусах өдөр, санал хураах өдөр, санал тоолох хугацаа, сонгогчдосон эрх баригчдын ажлаа хүлээн авч, засгийн газар байгуулах зэрэг үйл явдлуудын хуанлиг мэдэж байх шаардлагатай. Мөн ерөнхийлөгчийн болон хууль тогтоох байгууллагын сонгууль болох эсэх, хэзээ болохыг анхааралдаа авбал зохино.
- Бүх нийтийн санал хураалт болон орон нутгийн сонгуулийн хувьд өөр дүрэм журам үйлчилж болно. Үүнд сонгогчид бүх нийтийн эсвэл хэсэгчилсэн сонгуулиас өөрөөр хандаж болно. Тиймээс эдгээр ялгааг олж тогтоон, судлах нь зүйтэй.

3. Зааварчилгааны арга зүй

Зааварчилгаа нь аливаа улс орны ХМХ-д ажиллаж буй сэтгүүлчдэд, тухайн нөхцөлд сонгуулийн үеэр тэдэнд дэмжлэг үзүүлэх зорилгоор илгээгдсэн арвин туршлагатай зөвлөхүүдийн томилгоо гэж бид ойлгодог. Зааварлагч гэж нэрлэх зөвлөх бүр нь төрөл бүрийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хөтөлбөр хэрэгжих хугацаанд редакцийн хамт олон болон сэтгүүлч бүртэй өөрийн туршлагаас хуваалцаж, хамтран ажиллана. Зааварчилгааны хөтөлбөр хэрэгжих хугацаа нь богино байхаасаа илүүтэйгээр хэд хэдэн долоо хоног үргэлжилсэн тохиолдолд үр дүнтэй байх нь ажиглагдсан.

Зааварчилгаа нь уламжлалт сургалт семинараас үндсээрээ ялгаатай. Семинар нь ихэвчлэн ерөнхий лекцийн араас практик ажил дагуулдаг боловч тухайн улс орны ХМХ-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох боломж байдаггүй. Харин зааварчилгаа нь зааварлагчдад хамтран ажиллаж буй ХМХ, сэтгүүлчдэд тулгараад буй бэрхшээлтэй асуудлууд болоод тэдний нөөц бололцоог бодитоор харах боломж олгодог юм.

Ингэж ажиллах нь зааварлагчдад таатай нөхцөл бүрдүүлдэг бөгөөд тэдэнд өндөр шаардлага тавигдана. Учир нь зааварлагч нь мэдээний өрөөний зохион байгуулалтаас өгсүүлээд хувь хүний ажлын арга барилд дэмжлэг үзүүлэх, мэдээлэхээс эхлээд хянах, даалгах, товлох, түүнчлэн хэвлэмэл, өргөн нэвтрүүлгийн эсвэл интернэтэд суурилсан, мөн гар ажиллагаатай, электрон, аналог эсвэл тоон зэрэг ашиглагдаж буй техник хэрэгслийн талаар ойлголттой байх гээд сэтгүүл зүйн өндөр ур чадвар, өргөн хүрээний мэдлэгтэй байх ёстой. Сайн зааварлагч гэдэг нь бүхнийг мэдэх албагүй ч мэргэжлийн зөвлөгөөтэй холбоотой хэрэгцээ шаардлагаас хамаарч төрөл бүрийн үйл ажиллагааг янз бүрийн төвшинд явуулах чадвартай байх нь чухал билээ.

Зааварчилгааны үйл ажиллагааны амжилт нь зааварлагч болон хамтран ажиллагчдын аль алины зүгээс уг идэвх санаачлагад хандах хандлагаас ихээхэн шалтгаална. Зааварлагчид өөрсдийн ажил, мэргэжлийн туршлагаасаа бусадтай хуваалцах гэж ирсэн туршлагатай сэтгүүлчид мэтээр өөрсдийгөө харж, бусдад мөн тэгж ойлгуулбал зохино. Чухамдаа ингэж л ХМХ-д үзүүлэх үйлчилгээг санал болгох бөгөөд зааварлагч ч мөн өөрийгөө ийм хэлбэрээр хамтран ажиллах редакцийн хамт олон, сэтгүүлчдэд таниулах ёстой.

Хүндлэл сайшаал хүртэх

Ийм хандлага нь зааварлагчид хамт ажиллах хүмүүстээ удирдлагаас ногдуулсан шахалт хэмээн тооцогдох бус тэдний хүндлэл, сайшаалыг хүртэх боломжтой. Зааварлагчдын хандлага, харьцаа бол ажлын үр дүн, амжилтын үндэс юм. Зааварлагчид нь арвин туршлагаасаа үл хамаарч, өөрсдийгөө эрхлэгчид биш бөгөөд ХМХ-ийн ажлыг чиглүүлэх гэж ирээгүй гэдгээ байнга санаж байх нь зүйтэй. Тэд редакцийн бие бүрэлдэхүүний ажлын талбар дээр нь өөрсдийн мэдлэгийг түгээн, зөвлөгөө өгөх үүрэгтэй. Ингэхдээ тэдний мэргэжлийн хараат бус байдлыг хүндэтгэнэ. Энэхүү нарийн чимхлүүр ажил нь бусдыг чиглүүлж, захирах бус дэмжин сайшаахад орших бөгөөд түүний зорилго нь арвин туршлага хуримтлуулж, мэдээ бэлтгэхдээ тунгаан бодох чадвар эзэмших явдал юм. Зааварчилгааны энэхүү үзэл баримтлал нь үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд маш чухал билээ. Чухамдаа, үүнээс л

хамаарч редакцийн ажилтнууд өөрийн бүрэлдэхүүнд зааварлагчийг оруулах саналыг хэрхэн хүлээн авах, мөн сэтгүүлчид өөрсдийн өдөр тутмын үйл ажиллагаанд гадны хүн оролцохыг хэрхэн авч үзэх зэрэг асуудлууд шалтгаалдаг.

Мэргэжлийн бэлтгэл сургуулилтын салбар дахь идэвх санаачилгуудын нэгэн адилаар, зааварчилгааны арга зүй нь хөтөлбөрийн агуулга, чиглэлийг боловсруулахдаа ХМХ-ийн удирдлагуудтай урьдчилан тохиролцохыг шаарддаг. Зааварчилгаа гэдэг нь зааварлагчдыг ХМХ-ийн ажилтнууд болон удирдлагатай мөр зэрэгцэн ажиллах мэдээний өрөөнд байлцуулахтай холбоотой өөр хандлага учир зааварчилгааны талаар илүү нарийн тайлбар хэрэгтэй. Үүний зэрэгцээ, тухайн хандлагын нэг давуу тал нь ХМХ-ийн ажилтнууд семинарт суухгүйгээр редакц дээрээ өөрсдийн ажлаа үргэлжлүүлэн хийх боломж юм. Тухайн үйл ажиллагааг удирдан явуулж буй байгууллагууд нь зааварлагчдын ажлыг ажигладаг. Эдгээр байгууллагууд нь ихэвчлэн хэвлэлийн эрх чөлөөг дэмжиж, нэн тэргүүнд ардчилал хөгжиж буй орнуудын хэвлэл мэдээллийг илүү мэргэшсэн болгох чармайлтыг дэмжих талаар мэргэшсэн олон улсын байгууллага байна. Арга хэмжээний болон мэргэжилтэн бэлтгэх ийм хэлбэрийг зөвхөн сонгуулийн нөхцөлд ч бус мөн бусад цаг үед хэрэгжүүлэх боломжтой гэдгийг хэлэх нь илүүц.

Зааварлагчдыг ажиллах газар руу нь илгээхээс өмнө тэднийг бэлтгэхэд онцгой анхаарах шаардлагатай. Уг гарын авлага тус зорилгыг хэрэгжүүлэх чухал хэрэгсэл болно. Зааварлагчид гарын авлагад агуулагдсан бүх асуудлуудыг авч хэлэлцэх бэлтгэл зөвлөгөөн зохион байгуулбал зохино. Тухайлбал, хийж гүйцэтгэх ажил үүрэг, тухайн улс орны түүх, улс төрийн нөхцөл байдал, болох гэж буй сонгуулиуд, хүлээгдэж буй хэрэгцээ шаардлага, мөн үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа, тухайн орны амьдралын болон ажиллах нөхцөл г.м. болно.

Зааварлагчид өдөр бүрийн төгсгөлд хүн бүрийн ажлыг авч хэлэлцэхийн тулд хянагч байгууллагын зохицуулагчидтай зөвлөлдөх уулзалт хийх нь үр дүнтэй байдаг. Зааварлагчдын хуримтлуулсан туршлага нь шинээр ажиллах ХМХ бүрт өөрчлөгдөх бөгөөд үйл ажиллагаагаа тухайн нөхцөл байдалд тохируулах шаардлагын улмаас багийн гишүүд бие биетэйгээ туршлага хуваалцах нь ихээхэн ач холбогдолтой. Хэвлэл мэдээллийн зарим удирдлагууд/өмчлөгчид зааварлагчидтай өөрсдийн байгууллагын асуудлаа нээлттэй хэлэлцдэг атал, нөгөө хэсэг нь зөвхөн сэтгүүлчдийнхээ арга барил, чадварыг дээшлүүлэх тал дээр анхаарлаа хандуулахыг хүсч болно. Өдөр тутмын эдгээр уулзалтууд нь учирч буй саад бэрхшээлээ хуваалцаж, багийн хамтын ухаанаар тодорхой ХМХ-ийн тухай асуудлыг шийдвэрлэх болоод үйл ажиллагаанд оролцогчдын дунд хамт олны уур амьсгалыг бэхжүүлэх сайн арга болдог.

Зааварлагчид хүндлэл сайшаал хүртэх хамгийн сайн аргуудын нэг нь редакцийн үйл ажиллагаанд, жишээлбэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хурал зөвлөгөөнд оролцох явдал юм. Хэрэв ийм төрлийн хурал зохион байгуулагддаггүй бол санал болгож болно.

Зааварлагчид сэтгүүлчдийн хэвлэлийн бага хурлын болон бусад арга хэмжээний тогтмол мэдээ сурвалжлагыг дагалдах аваас илүү үр дүнд хүрэх боломжтой. Ингэж ажиллах нь зааварлагчид болон сэтгүүлчдийн хоорондын харилцааг мэргэжилтний хувьд бэхжүүлэхэд ач тустай гэдгийг Гаитийн туршлага харуулсан билээ.

Уян хатан, дасан зохицох чадвартай байх нь

Зааварчилгаа гэдэг нь үйлчилгээ үзүүлэгч олон улсын байгууллага болоод тухайн үйлчилгээг хүртэж буй ХМХ-ийн хоорондын сайн дурын идэвх санаачилга учраас зааварлагчид хамтран ажиллаж буй ХМХ-ийн удирдлага, сэтгүүлчидтэй тэргүүлэх чиглэлээ тодорхойлж болно. Зааварлагчдад үзүүлэх хүндлэл сайшаал, тэдний нөлөө нь үр шимийг хүртэгсэд түүнийг хэр чухал гэж үзэхээс үргэлж шалтгаалдаг. Удирдлага, сэтгүүлчдийн тогтоосон тэргүүлэх бүс нутаг нь зааварлагчдын харж байгаагаас өөр байвал ажлын төлөвлөгөөгөө түүнд тохируулах эсвэл өөрчлөхөөс өөр сонголт үлдэхгүй. Зааварчилгаа гэдэг нь тавигдаж буй зорилго хэр сайн байхаас үл хамаарч хүчээр тулгаж болох зүйл биш юм.

Тиймээс зааварлагч нь уян хатан, аливаа нөхцөлд дасан зохицох чадвартай хүн байвал зохилтой. ХМХ-ийг үйл ажиллагаагаа дүгнэхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх нь зааварчилгааны үйл ажиллагааны төгс хэлбэр юм. Ингэхдээ, зааварлагчтай хамтарч юун дээр анхаарал хандуулах, мөн ирээдүйд ямар асуудлуудыг авч хэлэлцэхийг илүү нарийвчлан тодорхойлох шаардлагатай. Харин зааварчилгаа нь тулгарч буй бүх асуудал, бэрхшээлийг хэдхэн долоо хоногийн дотор шийдэхгүй.

Зааварлагч хөтөлбөрийнхөө төгсгөлд тухайн нөхцөл байдлаас хамаарч ХМХ, сэтгүүлчдийн хамт эсвэл ганцаарчлан, хуримтлагдсан туршлагын тайлан бичих ёстой. Зааварлагч, сэтгүүлчдийн хамтарсан тайлан болон зааварлагчийн үйл ажиллагаа хариуцсан байгууллагадаа эргэн очихдоо бэлдсэн тайлан зэрэг нь илүү нарийвчилсан судалгаанд ашиглагдах нь гарцаагүй. Эдгээр тайланг бэлдэхдээ дараа дараагийн арга хэмжээ, хэвлэл мэдээллийн мэргэжлийг дээшлүүлэх асуудлыг харгалзан үзэх шаардлагатай. Ийм зөвлөмжүүд нь хэрэгцээ шаардлагын нарийвчилсан мэдлэг дээр тулгуурласан байдаг тул цаг үеэ олсон, чухал асуудал юм. Уг гарын авлагын төгсгөлд, түүнийг цаашид боловсронгуй болгоход ач холбогдол бүхий асуулгуудыг зааварлагчид ба түүний байгууллагууд бөглөх нь зүйтэй.

Орчуулагчид

Зааварлагчдыг хамтран ажиллах хүмүүсийнхээ хэл дээр ярих чадвартай эсэхээр сонгох ёстой. Гэхдээ зарим тохиолдолд зааварлагчдад түүнд томилсон орчуулагчийн туслалцаа шаардагдаж болно. Тиймээс хөтөлбөрийн удирдагчид, зааварлагчид орчуулагчтайгаа найрсаг харилцаа тогтооход анхаарах нь зүйтэй. Орчуулагчид нь хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн талаар ойлголттой байвал сайн. Гэхдээ тэрбээр ХМХ-ийн хооронд өрсөлдөгч байгууллагын ажилтан байх ёсгүй. Зааварлагчид нь орчуулагчдаа уг гарын авлагыг өгч, бүх агуулгатай нь танилцсан эсэхийг баталгаажуулах шаардлагатай. Үүнээс гадна, орчуулагч нь зааварлагчид болон бэлтгэгдэж байгаа хүмүүсийн үг, үзэл санааг зөв тусгаж чадах эсэхийг нягтлах хэрэгтэй. Зөвлөх үйл явц нь хурдан хэмнэлээр явагдах албан бус үргэлжилсэн ярилцлага байдаг тул зааварлагчтай ажиллахад хэд хэдэн орчуулагч шаардагдаж магадгүй.

4. Сонгууль сурвалжлах хэрэглүүр

4.1. Тайлбар зурвас

- тогтворгүй байдалтай хэвлэл мэдээлэл, сонгуулийн талаар зааварлагч болон сургагч нарт зориулсан.

Бэрхшээлүүд

Нийгэмд зөрчилдөөн буюу тогтворгүй байдал бий болсон улс орнуудад явагдах сонгууль бол сэтгүүлчдийн хувьд асар их бэрхшээлтэй асуудал байдаг. Энэ цаг үед олон нийт болоод хэвлэл мэдээлэл нь өөрчлөлт шинэчлэлт, тухайлбал төр засаг, улс төр болон улс төрчдийг өөрчлөх эрмэлзлийг дэмжин, анхааралдаа авна. Тэр бүү хэл ардчилал хөгжсөн орны хэвлэл мэдээлэлд ч сэтгэлийн хөөрлийг дэмжиж, намууд хоорондын өдөөн хатгалга, үгүйсгэлд анхаарлаа хандуулан, иргэдийн дуу хоолой, нийгэмд тулгарч буй бодит асуудлуудыг үл тоомсорлох хандлагууд илэрдэг.

Үнэн зөв, тэнцвэртэй, шударга, хариуцлагатай байх гэдэг сэтгүүл зүйн мэргэжлийн хэм хэмжээнд хүрээгүй нийгэмд эдгээр эрсдэл улам нэмэгддэг. Сул дорой хууль тогтоомж, мэргэжлийн үүргээ гүйцэтгэж буй сэтгүүлчдийн хязгаарлагдмал хамгаалалт бүхий орчинд, хэвлэл мэдээллийг төр засаг эсвэл авлига, улс төрийн сэдэлтэй өмчлөгчид хянаж байгаа нөхцөлд энэ бүх асуудал тохиож болзошгүй бөгөөд мэдээ, нийтлэл нь ихэвчлэн тал тохой татсан шинжтэй байдаг. Ийм орчин дахь мэргэжлийн сэтгүүл зүй хүртэл эцсийн үр дүнд нийгмийн итгэлийг алддаг байна.

Сонгууль нь сэтгүүл зүйн хувьд үнэхээр ноцтой бэрхшээл дагуулдаг. Гэсэн ч нээлттэй явагдаж, шударга ёсонд нийцэх өргөн цар хүрээтэй дүрэм журмаар хязгаарлагдсан, тайван замаар өөрчлөлт руу хүргэх асуудлыг шийдвэрлэхэд ардчилсан сонгууль нь аливаа зөрчилдөөний зохицуулагч байдаг. Эдгээр дүрэм журмыг удирдлага болгож, нийгэмд оршиж буй саад бэрхшээлийг ойлгож мэдэх, санал хураах байр руу сайн мэдээлэлтэй явж сонголтоо хийхэд нөлөөлөх үйл явцад хувь нэмэр оруулах нь сэтгүүл зүйн хамгийн сайн боломж билээ.

Сонгууль гэгч хууль ёсны “бужигнаан”-ы үед зааварлагчдын хэрхэн ажиллахыг сэтгүүлчдэд зааварчлан итгүүлэх нэгдмэл ёс зүй буюу зарчим, эсвэл ёс суртахууны хэм хэмжээ бол сонгууль чөлөөт, шударга явагдах ёстой гэдэг ухагдахуун юм. Чөлөөтэй гэдэг нь бүх нам эвсэл, нэр дэвшигч болон сонгогчдын үг чөлөөтэй гэсэн үг. Шударга гэдэг нь сонгуулийн кампанит ажил болон санал хураалт нь авлигагүй бөгөөд айх айдасгүй явагдахыг хэлнэ. “Чөлөөтэй, шударга” нь давамгайлахыг хэвлэл мэдээлэл боломжийн хэрээр хангах үүрэгтэй.

Мэргэжлийн ур чадвар нэн чухал

Мэдээллийн үнэн зөв, тэнцвэртэй байдал, ярилцлага авах, материалаа хянах чадвар гэдэг сэтгүүл зүйн үндсэн ур чадвар дутах аваас үйл ажиллагаанд дүрэм журам, горимын мэдлэг, мөн чөлөөт, шударга сонгуульд мэдээллээр хувь нэмэр оруулах ажил хангалтгүй явагдана гэсэн үг юм. Зааварлагчид мэргэшсэн байх нь сонгуулийн үйл явцыг сурвалжлах үндэс гэдгийг онцлохдоо мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх ажлыг сонгууль сурвалжлах сэтгүүл зүйн үйл ажиллагаатай байнга холбохыг эрмэлзэх

магадлалтай. Мэргэжлийн сэтгүүл зүйн ёс зүйг онцлох нь сэтгүүлчдийн, тэр бүү хэл өрсөлдөгч ХМХ-ийн хооронд холбоо тогтооход нөлөөлж болно. Ингэх нь хувь хүний хувьд үйл явдлыг мэдээлэхдээ шуугиан тарих, ялгаварлан гадуурхах буюу мушгин гуйвуулах зэргээс зайлсхийх боломж олгоно. Зааварчилгааны энэхүү аргын үнэ цэнэ нь мэргэжлийн сэтгүүлч-зааварлагчид сурвалжлагч, редакторуудтай ажлын талбар дээр хүртэл хамтран ажиллах, боломжит тохиолдол бүрт мэргэжлийн хэм хэмжээ болон зан байдал үзүүлж байдагт оршино.

Бие даалтын хэрэглүүр

Зааварлагчдад санал болгож буй энэхүү цогц хэрэглүүрийн тухай мэдээллийг олон эх сурвалжаас иш татсан бөгөөд зохиогчдын туршлага дээр үндэслэсэн юм. Зарим хэрэглүүр зааварлагчдад, зарим нь тэдэнтэй хамтран ажиллах сурвалжлагч, редакторуудад зориулагдсан. Эдгээр хэрэглүүрт сонгуулийн тухай ойлголт, сонгууль сурвалжлах арга хэрэгслийг багтдаг. Зааварлагчид ямар хэрэглүүрийг хэзээ ашиглахыг өөрсдөө шийдэх бөгөөд сурвалжлагчдад тэдгээрийг мэдээлэх ажилд нь удирдлага болохуйц хэрэглүүрийг хувиран тарааж болно. Сурвалжлагчдад зориулсан ИМПАКС, “Олон улсын хэвлэл мэдээллийн дэмжлэг” байгууллагуудаас эрхлэн гаргасан (ISBN 0-9733391-1-X, интернэтэд мөн тавигдсан байгаа) “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба сонгууль. Сонгууль сурвалжлах гарын авлага” (Media and Elections: An Elections Reporting Handbook) товч гарын авлагыг зааварлагч нар ашиглан, тараахыг зөвлөж байна.

4.2. Сонгууль сурвалжлах хэрэглүүр

Ардчилсан сонгуулийн үндсэн зарчмууд нь:

1. Сонгууль чөлөөтэй бөгөөд шударга явагдах ёстой
2. Хэвлэл мэдээлэл нь “мэдээлэх”, “хоточ нохой” байх, сонгогчдын “дуу хоолой” болох гэсэн гурван үүргээ биелүүлэх.

Зааварлагчид сонгууль бол тэдний мэдээ, нийтлэлд дүрслэгдэж буй эрчимтэй, урт удаан хугацааны чухал явц гэдгээс илүү нарийн ойлголт гэдгийг сэтгүүлчдэд мэдээлэх ёстой. Ихэнх улс орон, хувь хүмүүсийн хувьд сонгууль нь ирээдүйгээ шийдвэрлэх чухал алхам бөгөөд үр дүн нь ХМХ сонгуулийн кампанит ажил, санал хураалтыг хэрхэн мэдээлэхээс шалтгаална. Зааварлагчдад ХМХ-ийг нам эвсэл, нэр дэвшигчдийн талаар мэдээлэхээс дутахгүйгээр сонгуулийн үйл явцын шударга байдлын талаар мэдээлэхэд анхаарлаа хандуулахыг хөхиүлэн дэмжих нь чухал.

Сонгууль сайн явагдахын тулд чөлөөтэй бөгөөд шударга байх ёстой. Мэргэжлийн сэтгүүлчдийн сонгууль сурвалжлах явцад баримтлах хоёр чухал зүйл нь “чөлөөтэй, шударга” гэдэг ухагдахуунууд юм.

“Чөлөөтэй” гэдэг нь энгийнээр хэлбэл сонгуулийн кампанит ажлын явцад нэр дэвшигчид, нам эвслүүд, сонгогчид нь үгээ чөлөөтэй хэлэх нөхцөл бүрдсэн байх. Энэ нь улс төрийн тоглогчдод ХМХ-үүд адилхан хүртээмжтэй байх үүрэгтэй гэсэн үг юм. Энэ нь хэвлэл мэдээлэл тэднийг ялгаварлан гадуурхалгүй тэнцвэртэй мэдээлэхийг хэлнэ. (Эрх тэгш гэдэг нь тэнцүү гэсэн үг биш бөгөөд сонгуулийн кампанид оролцох

нам эвслийн эзлэх жингээсхамаарч нэр дэвших төлөөлөгчдийн тоо харьцааг хэлнэ.)

Сонгууль мөн шударга байх нь зайлшгүй. Иргэн бүрийг саналаа нууцаар өгөх боломжоор хангасан дүрэм журам батлагдсан байх шаардлагатай. Бүх нэр дэвшигч, нам, эвслүүд сонгуулийн кампанит ажил явуулахдаа хөндлөнгийн оролцоо, айх айдасгүйгээр тэгш эрх, адил боломж эдлэх ёстой. Ингэхдээ дүрэм журмыг ягштал дагаж мөрдөх шаардлагатай бөгөөд санал хураалтын үр дүнг хүн бүр хүндэтгэн үзвэл зохилтой.

ХМХ-ийн үүрэг

ХМХ нь сонгуульд дараахь гурван чухал үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Нэгдүгээрт, ХМХ нь хүмүүст сонгуулийн талаар мэдээлж байдаг. ХМХ нь хүмүүст харьцуулалт хийн, ялгаатай талыг ойлгож, сонгох боломжоо эдлэхэд нь улс төрийн бүх намуудын кампанит ажлын тухай шударгаар мэдээлбэл зохино. Үүнээс гадна, ХМХ нь тоймч, тайлбарлагч болон ток-шоуны хөтлөгчдийн санал бодлыг дамжуулж болно. Мөн сонгуулийн комиссоос нэр дэвшигчид гэж ямар хүмүүс болох, саналаа хаана өгөх, нууц санал хураалт хэрхэн явагдах талаар иргэдэд танилцуулах мэдээ, мэдээлэл хүргэнэ. ХМХ-ээр мөн улс төрийн намуудын хүмүүсийн дэмжлэг авах зорилгоор хийх сурталчилгааг нийтэлж, нэвтрүүлж болно.
2. Хоёрдугаарт, ХМХ нь сонгуулийн кампанит ажил, санал хураалтын шударга байдалд хяналт тавих “хоточ нохой” мөн. Чухамдаа, ХМХ нь зарим нэр дэвшигчид айх, эмээх гэдэг шалтгаанаар үгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөгүй байгаа талаар мэдээлэх үүрэгтэй. Мөн сонгууль болон санал хураах явцад авлига байгаа эсэх, Сонгуулийн комисс үүргээ шударгаар биелүүлж байгаа эсэхийг мэдээлэх нь зүйтэй.
3. Гуравдугаарт, ХМХ нь сонгогчдын “дуу хоолой” байх ёстой. Сонгууль гэдэг нь зөвхөн улс төрчдөд зориулагдаж явагддаггүй. Сонгууль жирийн иргэдэд үгээ хэлэх боломж олгож, тэдний бодлоор ямар асуудлууд яагаад чухал гэдгээ илэрхийлэх боломж юм. ХМХ нь ард түмний дунд орж, үгээ хэлэх гэсэн жирийн сонгогчдын “дуу хоолой” нь болж, үгээ хэлж чадахгүй байгаа, урьд өмнө нь үл тоомсорлогдож байсан хүмүүсийн “дуу хоолой” нь байх ёстой.

Сонгуулийн кампанит ажлын гурван зүйл

Сонгуулийн комисс нь сонгуулийн кампанит ажил явуулах тухай дүрэм журам батална. Уг журамд ХМХ мэдээлэл хүргэхдээ шударга байдлыг хэрхэн хангах тухай заалт орж болох боловч тэдний анхаарлаа хандуулах асуудал, мэдээлэх зүйлийн тухай заалт байдаггүй.

Ардчилсан сонгуулийн үеэр сэтгүүлчид юуг анхаарах вэ?

Санал хураах өдрийн өмнөх кампанит ажлын явцад ХМХ дор хаяж гурван зүйлийг мэдээлсэн байх ёстой. Үүнд:

1. Улс төрийн нам, нэр дэвшигчид.

ХМХ нь намуудын эрх мэдэл, нэр хүнд, нам, эвслээс нэр дэвшигчдийн тоо, хамардаггүй хүрээ, бүлгийн талаар мэдээлэх ёстой. ХМХ нь сонгогчдод сонгуульд оролцогч нам тус бүрийн талаар мэдээлэл өгөх нь зүйтэй. Гэвч олон нэр дэвшигчтэй том намуудын тухай илүү мэдээлэл түгээх магадлалтай байдаг. Мөн бие даан нэр дэвшигчдийн талаар мэдээлбэл зохино.

2. Дэвшүүлж буй асуудлууд.

Улс төрийн нам, эвсэл бүрт өөрсдийн хамгийн чухал гэж үзсэн асуудал, сонгогчид яагаад уг намыг сонгох хэрэгтэй гэдэг талаар өөрсдийн үзэл бодол байдаг. ХМХ нь нам, эвслүүдийн нэг чухал асуудлаар тухайн намаас баримталж буй бодлогын ижил төстэй болон ялгаатай талыг мэдээлж, сонгогчдод харьцуулалт хийхэд нь мэдээллээр хангах. Сонгууль сурвалжлах мэргэжлийн сурвалжлага нь ямар сонголт нь илүү гэдгийг сонгогчдод хэлэх ёсгүй. Сурвалжлагчид нь редактор, тоймч, тайлбарлагчдад энэ үүргийг үлдээнэ. ХМХ нь хүмүүсийн чухал гэж үзэж буй боловч зарим улс төрчдийн хөндөх дургүй асуудлуудыг мөн олж тодорхойлох нь зүйтэй.

3. Санал өгөх явц

Сонгуулийн комисс, ХМХ-ийн аль аль нь хүмүүсийн оролцоог хангахын тулд сонгуулийн явцын талаар мэдээлнэ. Энэ нь сонгогчид хэрхэн бүртгүүлэх, кампанит ажлын үргэлжлэх хугацаа, саналыг хэн тоолох, намуудын кампанит ажилд зарцуулах хөрөнгө мөнгө болон өөр бусад асуудлуудыг багтаасан байна. ХМХ нь санал хураах явцыг ажиглаж, дүрэм журам нь авлига, тал засалгүйгээр аль ч намд адил тэгш мөрдөгдөж буй эсэх эсвэл сонгогчдын аль нэг бүлэг нь дүрэм журмын зөрчил гаргаж байгаа эсэхийг хянах үүрэгтэй.

Сонгуулийн комисс

Сонгуулийн комиссийг сонгууль чөлөөтэй, шударга явагдах нөхцөлийг хангасан дүрэм журам баталдаг, бүхэлдээ хараат бус байгууллага хэмээн үзэж болно. Гэвч мэдээ явуулдаг ХМХ сонгуулийн явц болон Сонгуулийн комиссыг анхааралтай ажиглах “хоточ нохой”-ны үүрэг гүйцэтгэх ёстой. Чөлөөт, шударга сонгууль явуулах үйл явц нь нарийн төвөгтэй учир сонгуулийн сурвалжлагчид Сонгуулийн комиссын талаар, түүний явуулж буй үйл ажиллагаа, сонгуулийн дүрэм журам, тэдгээр нь мөрдөгдөж буй эсэх тухай мэдээлэлтэй байх нь зүйтэй. ХМХ нь сонгуулийн дүрэм журмыг мэдэж байх аваас сонгуулийн кампанит ажлын талаар тодорхой мэдээлэх, Сонгуулийн комиссыг зохих арга хэмжээ авахуулахын тулд дүрэм журмын зөрчлийн талаар мэдээлэх боломжтой болно. ХМХ нь комиссын авах арга хэмжээний талаар мөн мэдээлдэг.

“Хоточ нохой” болох ХМХ-д зориулсан асуултууд:

- Эрх бүхий иргэн бүр сонгох эрхтэй юу? Санал өгөхийн өмнө сонгогчдын нэрс жагсаалтанд хэрхэн бүртгэгддэг вэ?
- Эмэгтэйчүүд болон цөөнхийн бүлгүүд санал өгөх явцад өөрсдийгөө аюулгүй байна гэж үздэг уу? Тэд санал хураах байранд учирч болох дарамтаас хамгаалагдах уу?

- Улс төрийн бүх нам, эвсэл айх айдасгүйгээр олон нийтийн цуглаан зохион байгуулах эрх тэгш боломжоор хангагддаг уу? Тэднийг хэрхэн хамгаалдаг вэ?
- Төрийн мэдлийн ХМХ-д улс төрийн бүх нам, эвсэлд шударга үндсэн дээр эфирийн болон нээлттэй мэтгэлцээний адил тэнцүү цаг гаргадаг уу?
- Төрийн албан хаагчид төвийг сахисан байр суурь баримталдаг уу? Эрх баригчид сонгуулийн кампанит ажлын үеэр аль нэг намд давуу эрх олгох ёсгүй. Цагдаа, хүчний байгууллага бүх намыг адил хамгаалах үүрэгтэй.
- Сонгуулийн штаб, хэсгийн хороодын аюулгүй байдал хангагдсан уу? Саналын хуудсыг хэн хамгаалдаг, үнэнч шударгаар тоолох асуудлыг хэн хариуцдаг вэ?

Цагдаа, хүчний байгууллага нь бүх нам, эвслийн хамгаалалтыг хариуцахгүй, тэдэнд төвийг сахисан байр сууринаас хандахгүй, эсвэл зарим иргэдийн сонгуульд оролцох эрхийг хязгаарлах нь мэдээлэх ёстой асуудал юм. ХМХ энэ тухай мэдээлэх үүрэгтэй. Сонгуулийн комиссыг хариу үйлдэл хийхийг шаардах ёстой. Уг асуудлын талаар бусад нам, эвслээс саналаа хэлэхийг шаардах ёстой. ХМХ нь мэдээ, мэдээллээрээ дамжуулан аливаа зөрчлийг илчилж, чөлөөт, шударга сонгуулийг хамгаалах үүрэг хүлээсэн байдаг.

Сонгуулийн комисс нь ХМХ-ийн үнэн зөв байдлыг хангах нь

Сонгуулийн комисс нь ихэнх тохиолдолд сонгуулийн кампанит ажил, санал хураах явцад ХМХ-ийн баримталбал зохих дүрэм журам баталдаг. Төрийн мэдлийн ХМХ болон бусад бүх ХМХ нь цацаж, нийтэлж байгаа мэдээний хэсэгт эсвэл нээлттэй мэтгэлцээнд бүх намуудын баримтлах байр суурины талаар мэдээлэх гэсэн шаардлага тусгаж болно. ХМХ улс төрийн зар сурталчилгааг хүлээн авах тухай дүрэм журам байж болно. Сурвалжлагчид болон мэдээний редакцийн удирдлагууд тухайн дүрэм журмын талаар мэдэж байх ёстой.

Өмчлөгчид нь сэтгүүлчээсээ аливаа намд давуу эрх олгосон мэдээ, мэдээлэл нэвтрүүлж, нийтлэхийг даалгасан ХМХ-ийн тухай яригдах аваас, Сонгуулийн комиссоос баталсан дүрэм журам нь мэргэжлийн сэтгүүлчдэд мэдээний тэнцвэртэй байдал шаардахыг нь хамгаалахад тусална. Сэтгүүлч ХМХ-ийн шударга, эрх тэгш хүртээмжийн талаар комиссоос гаргасан журмыг үндэслэж болох бөгөөд удирдлагадаа нэг талыг хэт баримталбал Сонгуулийн комисс торгууль шийтгэл ногдуулна гэдгийг тайлбарлах нь зүйтэй.

Өмчлөгчид болон мэдээний редакцийн удирдлагууд улс төрийн талаар баримталдаг үзэл бодлоо мэдээний нэвтрүүлгээс тусдаа илэрхийлж байвал зохилтой. Нэвтрүүлж, нийтэлж буй мэдээг редакцийн материалууд болон хэвлэл мэдээллээр илэрхийлж буй үзэл бодлоос салангид байлгах нь олон нийтийн ХМХ-д итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг.

Сонгуулийн комисс нь чөлөөт, шударга сонгууль явуулах зорилгоор сонгуулийн явцад жирийн үеийнхээс илүү хараат бус, олон талт хэвлэл мэдээллийн орчин бий болгож

болно. Гэвч Сонгуулийн комисст эрх баригчдын оролцоо, аль нэг намд давуу эрх олгох, авлига, нөөц чадвар хүрэлцэхгүй байх зэрэг бэрхшээлүүд тулгардаг. Тиймээс, ХМХ тэдний үйл ажиллагааг тал тохой таталгүй хянаж, мэдээлж байх үүрэгтэй юм.

Сонгуулийн кампанит ажлыг мэдээлэх нь

Ихэнх нам, эвслүүд сонгогчдод удирдагч нь таалагдах аваас тухайн намаас нэр дэвшигчдийн төлөө саналаа өгнө гэсэн үүднээс өөрсдийн удирдагчдыг анхаарлын төвд байлгахыг эрмэлздэг. Иймээс тухайн намын сонгуулийн кампанит ажил нь намын удирдагчаа онцолж, чухал байр суурь олгох илтгэл, намын хурал цуглаан, хэвлэлийн бага хурлаас бүрддэг. Гэвч хэвлэл мэдээллийн ажил нь удирдагчдын хэлж байгаа үг бүрийг давтахаар хязгаарлагдахгүй. Мөн илтгэл хаана тавигдсан, хэдэн хүн оролцсон, жирийн иргэд үүнийг хэрхэн хүлээж авсан, улс төрийн өрсөлдөгчид энэ талаар юу гэж хэлснийг мэдээ, сурвалжлагандаа тусгах нь зүйтэй. Сонгогчид харьцуулалт хийж, бие даасан шийдвэр гаргах боломжтой байхын тулд мэдэх эрхтэй.

Улс төрийн нам, эвслийн төлөө тогтмол саналаа өгдөг сонгогчид болон шийдвэрээ гаргаагүй, тодорхой бус, тогтворжоогүй байгаа сонгогчид

Ихэнх улс төрийн намууд тэдний төлөө байнга саналаа өгч заншсан сонгогчдод найдвар тавьдаг бөгөөд тэдний саналыг баталгаатай, найдвартай байлгахын тулд амлалт өгдөг. Гэвч, үр дүн нь таагдашгүй байгаа сонгуулийн нөхцөлд, нам, эвслүүд зөвхөн өөрсдийн тогтмол сонгогчдын дэмжлэгэнд тулгуурлан сонгуульд ялалт байгуулах явдлыг хангаж чадахгүй. Тэдэнд анх удаа сонгууль өгч байгаа хүмүүс эсвэл хуучин намаараа сэтгэл хангалуун бус байгаа хүмүүс зэрэг тогтворжоогүй сонгогчдыг татах шаардлага тулгарна. Сэтгүүлчид тогтворжоогүй байгаа сонгогчдын санал бодлыг судалж, тэдний талаар мэдээлэхийн зэрэгцээ намууд дэмжлэгийг нь авахын тулд амлаж байгаа зүйлсийн талаар мэдээлэх шаардлагатай.

ХМХ-ийг ашигласан булхайгаас зайлсхийх

Ихэнх хүмүүс мэдээ явуулдаг ХМХ-ээр үзэж, сонсож байгаа зүйлдээ итгэдэг гэдгийг улс төрийн нам, эвслүүд андахгүй. Нам эвсэл бүр өөрсдийн удирдагч, нэр дэвшигчийг айл өр, сургуулиар зочлуулах, хүүхдүүдийг үнсэх, урам зоригоор дүүрэн хүмүүсийг угтан мэндчилэх зэрэг сэтгэл татахуйц “цоо шинэ” өөрсдөд нь ашигтай нөхцөл бүрдүүлэхийг чармайдаг.

Мэргэжлийн сэтгүүлчид нэр дэвшигчдэд ашигтай мэдээллийг үл тоомсорлож чадахгүй, учир нь бусад өрсөлдөгч ХМХ энэ талаар мэдээлэх болно. Сэтгүүлчийн хувьд, жирийн сонгогчдын нэрийн өмнөөс тухайн нам амлалтаа хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой асуулт тавих ёстой. Сэтгүүлчид нь нэр дэвшигчдэд ашигтай талаас нь мэдээлэх, бусад нэр дэвшигчдэд тэнцвэртэй хандахын тулд нөгөө нэр дэвшигчдийн дэвшүүлж буй асуудлуудад хариу үйлдэл үзүүлэхийг санал болгож болно. Асуултууд нь эелдэг бөгөөд хүндэтгэсэн байвал зохилтой бөгөөд жирийн сонгогчдын нэрийн өмнөөс, чөлөөт, шударга сонгуулийг хангах ашиг сонирхолын дагуу тавигдах ёстой. Сонгууль нь улс төрчдийн төлөө бус сонгогчдын төлөө явагддаг гэдгийг мартаж болохгүй.

Илтгэлийг мэдээлэх нь

Улс төрийн илтгэл нь тухайн намыг дэмжиж заншсан дэмжигчдийн үнэнч байдлыг

сэргээх, мөн асуудлыг нь шийдэж, амьдрал ахуйг нь дээшлүүлэх амлалтуудаараа шинэ дэмжигчдийг татах зорилго агуулдаг. Мөн бусад нам эвслийг сул дорой эсвэл авлигад өртсөнөөрөө сонгогчдын сэтгэл татамгүй гэж харуулахыг зорьдог. Гэвч илтгэл нь дайрч довтолсон үг хэллэг хэрэглэж, бусад улс төрчид руу дайрах сэтгэл хөдлөлийг бадраах боломжтой. Үүнийг сэтгүүлчид цензургүй бөгөөд үнэн зөвөөр мэдээлэх үүрэгтэй. Гэвч дайрах өнгө аяс агуулсан мэдээ нь дайрлаганд өртсөн нөгөө талын шуурхай хариу үйлдлээр боломжийн хэрээр тэнцвэржүүлэгдэх шаардлагатай бөгөөд илтгэлийн тухай мэдээ, сурвалжлаганд тусгагдах ёстой. Жирийн сонгогчдын хариу үйлдлийг ч бас тусгах нь зүйтэй.

Мэргэжлийн сэтгүүлчид мэдээ бэлтгэхдээ өөрийн үзэл бодол буюу шүүмжлэлээс зайлсхийвэл зохино. Мэргэжилтнүүд төвийг сахисан бөгөөд үнэнч шударга байх ёстой тул илтгэлийн явцад хөөргөн дэмжиж, алга ташдаггүй.

Үзэн ядалт өдөөсөн мэдэгдэл

Үзэн ядалт өдөөсөн мэдэгдлийг явал зохилтой вэ? Үзэн ядалт өдөөсөн мэдэгдэл нь зарим хүмүүсийг харъяалагдаж буй овог аймаг, нийгмийн бүлэг, шашин шүтлэгээс хамааран хүнлэг бус гэдгийг ойлгуулахыг оролдсон, эдгээр хүмүүсийг бүлгийнх нь хувьд устгахыг уриалан дуудсан эртний номлол, зүйрлэл зэргийг агуулсан үгийн бүх төрлийн хэлбэр юм. Үзэн ядалт өдөөсөн мэдэгдлийг хийж байгаа хүн нь нэр нөлөө бүхий эрхэм байх аваас, энэ тухай заавал мэдээлэх ёстой. Үзэн ядалтыг уриалан дуудсан мэдэгдлийг хариу үйлдэл үзүүлэлгүй орхиж хэзээ ч болохгүй. Иймэрхүү төрлийн мэдэгдлүүд нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн зөрчил мөн. Сэтгүүлчид нь үзэн ядалт өдөөсөн мэдэгдлийн хариуд хараат бус шинжээч, хүний эрхийг хамгаалагчдын үзүүлэх үйлдэл, мөн үзэн ядалт өдөөсөн мэдэгдлийн дайрлагад өртөгсөдийн хариу үйлдлийг олж илрүүлэхийн тулд хичээн чармайж, тэдний санал бодлыг мэдээ, нийтлэлдээ тусгах шаардлагатай.

Олон нийтийн санал асуулга – Хууртахгүй байх

Улс төрийн нам, эвслүүд нь сонгогчдын аль бүлэгт ямар асуудал чухал гэдгийг олж илрүүлэхийн тулд олон нийтийн санал асуулгын арга ашигладаг. Санал асуулга олон нийтийн дунд ямар асуудал илүү нийтлэг байгааг харуулдаг тул намууд зарим тохиолдолд кампанит ажлын амлалтуудаа өөрчлөхөд хүрдэг. Санал асуулга нь сонгогчид зэргэлдээ байгаа хүмүүсийн санаа бодлыг мэдэхийг хүсч, тэдний нэгэн адил саналаа өгөх шийдвэр гаргах магадлалтай тул сонгогчдод ч мөн нөлөөлдөг юм.

Гэвч санал асуулга нь тухайн цаг мөчид хариулт өгч байгаа хүмүүсийн санал бодлын товч илэрхийлэл юм. Санал асуулга нь сонгогчид шинэ мэдээлэлтэй болоход тэдний санал бодол, шийдвэр хэрхэн өөрчлөгдөхийг урьдчилан хэлж чадахгүй. Тиймээс санал асуулга нь өдөр бүрийн онцлох мэдээ, сурвалжлага байх шаардлагагүй. Учир нь

сонгогч болон ХМХ-ийг бие даан эргэцүүлэн бодохоос илүү түгээмэл санаа бодлыг дагахад нөлөөлж болно.

Санал асуулгыг улс төрийн намууд болон бусад сонирхогч талууд сонгогчдод нөлөөлөхийн тулд буруугаар ашиглах магадлалтай. Сэтгүүлчид нь мэргэжлийн байгууллагуудын явуулж буй санал асуулгын талаар мэдээлж байх шаардлагатай бөгөөд тухайн цаг мөчид хүмүүсийн санал бодлын үнэн зөв дүр төрхийг харуулахад дүрэм журмыг ягштал дагаж мөрдөх хэрэгтэй. Олон нийтийн санал асуулга явуулдаг мэргэжлийн байгууллагуудын ажил юун дээр үндэслэгддэг гэдгийг олж мэдэх нь зүйтэй.

Сонгогчдын дуу хоолойг мэдээлэх нь. Нэр дэвшигчдээс сонгогчдын асуултад хариулт авах

Сонгуулийн кампанит ажил улс төрчдийн бус сонгогчдын хүсэл сонирхлын дагуу явагдах ёстой. Чухамдаа сонгогчид л санал өгөх өдөр чухал шийдвэр гаргана. Сонгуулийн сурвалжлагчийн өмнө тулгарч буй томоохон зорилтуудын нэг бол улс төрчдийн илтгэл, хэвлэлийн бага хурлаар тэдний үүсгээд байгаа шуугианд авталгүйгээр сонгогчид, бусад иргэдийн хүсэн хүлээж буй зүйлийг мэдээлэх.

Сонгогчийн нэгэн адил бодох

Үйл явдлыг хараат бусаар сурвалжлахад яах вэ гэдгээ шийдэхдээ ХМХ нь өөрийгөө сонгогчийн “дуу хоолой” гэж үзэх хэрэгтэй. Ийм хандлага нь сэтгүүлчдэд нам эвслийн кампанит ажлын хүрээнээс гадуур ярилцах шаардлагатай хүмүүс болон сэдвийг олоход тусалдаг. ХМХ нь энгийн хүмүүсийн бодож, ярьж байгаа зүйлсийг мэдээлж байх нь зүйтэй. Хүмүүсийн бодож санадаг зүйл нь ерөнхийдөө тэдний аюулгүй байдал хангагдсан байх, баталгаатай ажилтай байх, цэвэр ус ууж, хүүхдүүдээ боловсролтой болгох юм. Тэд шинэ гүүр бариулж, чанартай замаар давхин, хямд шатахуун хэрэглэхийг хүсдэг. Хүмүүс нь эдгээр асуудлуудыг шийдэхийн тулд янз бүрийн улс төрчид ямар алхам хийхийг олж мэдэхийг эрмэлздэг. ХМХ-ийн сонгогчдын “дуу хоолой” болох үүрэг нь эдгээр асуудлуудыг улс төрийн намуудын сонорт хүргэн, сонгогч хэний төлөө саналаа өгөх вэ гэдгийг шийдвэрлэх хариу үйлдэл хүлээн авахад оршино.

Сонгогчийн дуу хоолойг хүргэхэд үнэн зөв, шударга бөгөөд тэнцвэртэй байдлыг шаардах нь зүйн хэрэг. Нийгмийн өмнө тулгараад буй асуудлуудыг ил гаргаж ирэхэд нийгмийн хараат бус зүтгэлтнүүд болон нэлээн тооны иргэдтэй ярилцахын тулд цаг хугацаа болон хүч чармайлт их шаардагдана. Тиймээс сонгогчийн адил бодох нь зөвхөн илтгэл мэдээлснээр хязгаарлагдахгүй, илүү олон мэдээ, сурвалжлага хийх шаардлага тулгарна. Энэ нь мөн тэднийг улс төрчдөд чухал асуултууд тавихад хүргэдэг.

Ток-шоу болон утсаар шууд холбогддог нэвтрүүлгүүдээр хөтлөгч нь сонгогчдоос тэдний улс төрчдөд тавихыг хүсч байгаа асуултуудыг тавьж, сонгогчийн “дуу хоолой” болж болно. Хөтлөгчид ч мөн сонгогчдод хандан асуудлыг хэрхэн шийдэж болох талаар өөрсдийн санал бодлыг хэлэхийг хүсч болно. Улс төрчдийг ток-шоунд оролцох эсвэл ярилцлага өгөхөд эдгээр асуултууд хийгээд боломжит шийдлүүдийг гарган тавьж хариулт авч болно.

Сонгогчдын “дуу хоолой” байх нь ХМХ-ийн ганцхан үүрэг биш юм. ХМХ нь намууд болон нэр дэвшигчдийн хэлж ярьж байгаа зүйлсийг, тэдгээр нь хүмүүсийн хэлэлцэхийг хүсч буй асуудлуудыг тусгаж чадаагүй байсан ч мэдээлж дамжуулах үүрэгтэй. Эцсийн эцэст, сонгогчид хэний төлөө саналаа өгөхөө өөрсдөө л шийдэх ёстой.

Өөр санал бодол, өөр бүлгийн дуу хоолойг эрэлхийлэх нь

Эмэгтэйчүүд, цөөнхийн бүлэг болон ядуус зэрэг чимээгүй байхыг илүүд үзэж, санал бодлоо илэрхийлдэггүй бүлгүүд байдаг. ХМХ нь тэдний “дуу хоолой” байхыг эрмэлзэх ёстой. Мөн фермерүүд, багш нар, наймаачид эсвэл ахмад дайчид зэрэг амьдарч буй орчноороо бус эрхэлж буй ажлаараа нэгдсэн бүлгүүд байдаг бөгөөд тэдэнд өөрсдийнх нь хувьд чухал боловч улс төрчдийн үл тоомсорлодог олон асуудал байдаг.

Гэвч сэтгүүлч нь эмзэг бүлэгт хамаарах эмэгтэйчүүдийн дуу хоолойг яаж хүргэх вэ? Тухайлбал, эмэгтэйчүүдийн дундаас удирдагчийг нь олж болно. Эмэгтэйчүүдийн цуглардаг газрыг асууж сурагла. Эмэгтэйчүүдийн асуудлаар мэргэшсэн их сургуулийн профессор болон хүний эрхийн мэргэжилтнүүд зэрэг хүмүүсийг эрж хай. Эмэгтэйчүүдийн дунд санал асуулга явуул. Сонгогч эмэгтэйчүүд харьцуулалт хийж, хэний төлөө саналаа өгөхөө шийдэхийн тулд тэдний дэвшүүлж буй асуудлыг нэг бус нэгжгээд улс төрийн удирдагчийн сонорт хүргэх нь зүйтэй.

Улс төрийн зүтгэлтнүүдээс ярилцлага авах нь

Сэтгүүлч хүний аливаа мэдээ, сурвалжлага хийхэд тавих үндсэн зургаан асуултууд нь: *Хэн? Юу? Хэзээ? Хаана? Яагаад? Хэрхэн?*

Гэвч улс төрийн нэр дэвшигчдтэй ярилцлага хийхэд илүү үр дүнтэй хариулт авах гурван асуулт байдаг. Эдгээр нь: *Юу? Яаж? Яагаад?*

Жишээлбэл, улс төрчөөс асуухдаа: Тосгоны гудамжаар урсах бохир усны асуудлыг шийдвэрлэхийн тулд танай нам юу хийх вэ? Тосгон ийм удаан хугацааны турш танай засгийн газрын анхаарлын гадна хэрхэн үлдсэн байна вэ? Энэ олон жилийн турш тосгонд яагаад бохир зайлуулах болон ус цэвэрлэх төхөөрөмжүүдийг суурилуулаагүй юм бэ?

Эдгээр асуултууд нь нэр дэвшигчийг хариултаа бодоход хүргэдэг. Ингэсэн тохиолдолд хэлэлцүүлэгт цэг тавих “тийм”, “үгүй” гэсэн товч хариултаар дуусгах боломжгүй тул эдгээр асуултуудыг нээлттэй хэмээн нэрлэдэг.

Бусад хэрэгтэй зөвлөгөө:

- Товч асуулт тавьж бай. Хэрэв та урт тайлбараар эхэлсэн асуулт тавих юм бол улс төрч нь урт тайлбараар хариулж, таны асуултыг ойшоолгүй орхино.
- Нэгэн зэрэг хоёр асуулт бүү тавь. Улс төрч хариулахад амарханыг нь сонгон, зөвхөн түүнд л хариулах болно.
- Ярилцлага авахын өмнө судалгаа хий. Тухайн хүн урьд өмнө юу ярьж байсныг олж мэд. Олон нийт тухайн улс төрчөөс юу асуухыг хүсч байгааг олж тогтоо. Өрсөлдөгчид болон шүүмжлэгчдийн санал бодлыг олж мэд. Шүүмжлэлд хариулт өгөхийг улс төрчөөс хүс.
- Ярилцлага эхлэхээс өмнө асуултуудаа боловсруул. Түүний дотор нээлттэй асуултууд тавихад бэлд.

Сонгуулийн кампаний хамгаалалт болон аюулгүй байдал:

- Улс төрийн намуудын билэг тэмдэг бүхий өнгийн хувцас, намуудын тэмдэг болон улс төрийн уриа бүхий хувцас бүү өмс.
- Улс төрийн нам, нэр дэвшигчдийн зүгээс үзүүлэх анхаарал, дэмжлэгийг бүү хүлээн ав. Мэдээнд явахдаа үнэгүй унаагаар үйлчлүүлэх шаардлагатай байсан ч мэдээг үнэн зөв, тэнцвэртэй хүргэх ёстой.
- Сэтгүүлч мөн гэдгийг баталсан биеийн байцаалт, бичиг баримт биедээ авч явж бай.
- Ямар ч тохиолдолд буу зэвсэг биедээ бүү авч яв. Зэвсэглэсэн сэтгүүлчийг довтлогч (террорист) хэмээн андуурах боломжтой.
- Маш аюултай хэмээн үзсэн үүрэг даалгавраас сэтгүүлчид татгалзах эрхтэй.
- Сэтгүүлч нь аюултай томилгоонд оролцохдоо хэрэгцээт тоног төхөөрөмж болон даатгалаар хангагдсан байх шаардлагатай.
- Ажил олгогчдоо аливаа халдлага, сүрдүүлэг заналхийллийн талаар заавал дуулгаж бай. Хэвлэл мэдээллийн бүх байгууллага нь сэтгүүлчийн эсрэг үйлдсэн аливаа сүрдүүлэг, заналхийллийн талаар мэдээлж байх үүрэгтэй бөгөөд сонгуулийн комиссоос сэтгүүлчдийг хамгаалахыг шаардах ёстой.
- Өөрийн редактор, хамт ажиллагсад эсвэл гэр бүлийн хүмүүс зэрэг бусад хүмүүст хаашаа явах, хэзээ эргэн ирэхээ заавал хэлж бай.
- Сэтгүүлчдийн эсрэг сүрдүүлэг заналхийллийн хамгийн сайн хамгаалалт бол түүний мэдээ, сурвалжлага тэнцвэртэй бөгөөд аль нэг талыг баримтлаагүй гэдгийг харуулах явдал юм. Хоёр талын үйл ажиллагааг мэдээлэх нь сонгогчдод харьцуулалт хийж, сонголтоо хийх боломж олгодог.

Санал хураалт, түүний үр дүн

Санал өгөх өдөр нь мэдээ, сурвалжлагын онцлох үйл явдал мөн. Яагаад гэвэл, ХМХ нь сонгогч бүр нууцаар санал өгөх эрхийг хангах, саналын хуудас бүрийг үнэнч шударгаар тоолох, үр дүнд нь булхай гарахгүй байхыг хангахын тулд чадах бүхнээ хийх ёстой.

Энэ нь Сонгуулийн комиссоос баталсан санал хураах дүрэм журмын талаар ойлголттой байж, эдгээр журмууд мөрдөгдөж буй эсэхэд ажиглалт хийхийг хэлнэ.

Санал өгөх явцад булхай луйвар, хөндлөнгийн оролцоо байх аваас, энэ талаар тухайн хүрээнд нь мэдээлэх ёстой. Бусад бүс нутагт санал хураалт зөрчилгүй, шударга явагдаж байж болох шүү дээ. Саналыг луйвардах ганц нэг тохиолдол нь сонгуулийг тэр чигт нь хүчингүй болгохгүй. ХМХ нь мэдээлэл дамжуулахдаа маш болгоомжтой ажиллах шаардлагатай бөгөөд саналын хуудасны тооллогын талаар үнэн зөв мэдээлэл дамжуулах үүрэгтэй. Алдаатай мэдээлэл нь өдөөн хатгах шинж агуулна.

Сурвалжлагчид ямар ч тохиолдолд өөрсдөө санал өгөх явцад оролцох ёсгүй.

Сонгууль сурвалжлах нь санал тоолж, үр дүнг нь зарласнаар дуусгавар болохгүй. ХМХ нь санал хураалтын хандлагууд, нэр дэвшигчдийн алдар хүнд өөрчлөгдөх, түүний шалтгаан, үр дүнд нь иргэд сэтгэл хангалуун байгаа эсэхийг задлан шинжилж, мэдээлэх ёстой. Шинэ засгийн газрын хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс ялагч намын өгсөн амлалтуудыг олон түмний сонорт хүргэх нь зүйтэй. Мөн шаардлагатай тохиолдолд, нэр дэвшигчид хангалттай санал аваагүй тойргуудад нөхөн сонгууль явуулах бэлтгэлийн талаар мэдээлбэл зохино.

Сонгууль сурвалжлах үзэл баримтлал

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ихэнхдээ сонгуулийн сурталчилгаа хийх өөрийн загварыг боловсруулдаг. Цуврал, хөтөлбөр гэх мэтийн ийм загвар нь сонгуулийн үйл явцыг өргөн хүрээтэй, тэнцвэртэй тусгах зорилготой, санал өгөх үедээ хувийн сонголт хийхэд нь сонгогчдод зориулсан мэдээллийн нэг хэсэг юм.

Цуврал:

- Өгүүлэл, өргөн нэвтрүүлгийн цувралд тухайн нам, нэр дэвшигчийг сорин шалгадаг бөгөөд төгсгөлд нь чухал нөлөө бүхий намуудад шударга, төлөөлөл нь жигд байхаар бодож тооцоолох ёстой
- Тухайн нэг сэдвээр ярилцлага хэлэлцүүлэг хийх.
- Долоо хоног бүр гол намын төлөөлөл, мөн жижиг намуудын зарим төлөөллийг урьж, нэг чухал асуудлаар тухайн намаас баримталж буй бодлогын ижил төстэй болон ялгаатай талыг хэлэлцэх. Энэ нь сонгогчдод харьцуулалт хийх, тэрхүү асуудлаар дөнгүүр бодлоготой гэж үзсэн намаа сонгох боломж олгодог
- Улс орныг хамарсан шууд утас ажиллуулах. Нэвтрүүлэх танхимд цугларсан намуудын төлөөлөл, сэдвийг нь урьдчилан зарласан онцгой, халуун сэдвээр эх орныхоо өнцөг булан бүрээс утасдах сонсогч, үзэгчдийн асуултад хариулна. Энэ загвараар бол сурталчилгааны туршид улс төрийн гол бүх намыг хамруулж, бүхий л гол сэдвийг хэлэлцэнэ

Сонгуулийн хөтөлбөрийн тогтсон загвар нь уран бүтээлийн баг буюу редактор, судлаачдад урьдчилан судалгаа хийх, хэлэлцүүлэг хэрхэн өрнөхийг урьдчилан таамаглах, зайлшгүй шаардлага бүхий онцлох зүйлүүдэд анхаарал төвлөрүүлэх боломж олгодог давуу талтай юм. Энэ явцдаа мөн өмнө бэлтгэсэн хөтөлбөр, хамарсан асуудлуудаа эргэн харах, хэрэгтэй гэж үзвэл тэдгээрээс иш татах, эцэст нь цувралуудын тэнцвэртэй байдлыг хангах шаардлагатай.

Зөрчлийг мэдрэмжтэй сурвалжлах нь

Сонгуулийн сурвалжлага бол зөрчлийн тухай юм. Сонгуулийн үр дүнд өөрчлөлт гарч болзошгүй бөгөөд түүнийг хэрхэн гэтлэх нь сонгуулийн асуудал юм. Засгийн газар өөрчлөгдөх үү, эсвэл Засгийн газрын бодлого өөрчлөгдөх үү, эсвэл иргэдийг төлөөлж буй хүмүүс өөрчлөгдөх үү? Зарим нь тийм гэдэг, нөгөө хэсэг нь үгүй гэдэг. Энэ бол улс төрийн зөрчил юм. Ардчилсан сонгууль бол улс төрийн зөрчлийг хүчирхийлэлд хүрэхээс өмнө тайван замаар шийдвэрлэх арга юм.

Улс оронд бий болсон гүнзгий үл зөвшилцөл улс төрийн зөрчилд хүргэж болзошгүй тул сурвалжлагчид үүний мөн чанарыг ойлгох ёстой. Зарим хүмүүсийн шаардаж буй, эсвэл нөгөө заримынх нь эсэргүүцэж буй өөрчлөлт юу юм бэ? Үндсэн асуудал нь юу вэ? Өөрчлөлтийг хүсэж буй, эсвэл эсэргүүцэж буй хүмүүсийг хэн төлөөлж байна вэ? Зөрчлийн уг үндсийг мэдрэх нь сонгуулийн үеэр гагцхүү улс төрийн мэтгэлцээний тухай сурвалжлах бус, харин түүнээс илүү мэдээллийг сурвалжлагчдад өгдөг.

Зөрчлийн эх сурвалж

Хүнс, орон сууц, ажил гэх мэт ховордмол нөөцийн тэгш бус хүртээмж нь зөрчлийн хамгийн нийтлэг шалтгаан юм. Ядуурал зөрчлийг тэтгэдэг. Зөрчил нь мөн өөр өөрийн тухай худал ташаа итгэл үнэмшил бүхий хэсгийн бүлгийн харилцааны доголдоос үүдэлтэй байж болно. Жендер, арьс өнгө, нийгмийн давхраа, эсвэл шашнаас үүдэлтэй тэгш бус хандлагыг хөөрөгдсөн хууль тогтоомж зөрчлийг дэвэргэж болно. Урт удаан хугацаанд тогтсон авлига, хөрш зэргэлдээ хэсэг бүлэг, улс орноос айх айдас ч мөн зөрчил үүсгэж болзошгүй. Тайван замаар, ардчилсан улс төрийн аргаар шийдвэрлээгүй зөрчил эцэстээ хүчирхийлэл болон хувирдаг.

Зөрчлийн мэдрэмжийн тухай мэдээллийг агуулсан “Зөрчлийн мэдрэмжтэй сэтгүүл зүй. Сурвалжлагчдад зориулсан гарын авлага”-ыг IMPACS болон IMS (ISBN 87-989502-0-7) байгууллагуудаас эрхлэн гаргасан бөгөөд цахим хуудаснаас мөн үзэж болно.

Үгээ нямбай сонгох нь

Сэтгүүлчдийн хувьд бидний сурвалжлага, мэдээнд хэрэглэж буй үгс нэг бол ойлголт өгдөг, эсвэл үл хүлээн авахад хүргэж, нөгөө бол айдас төрүүлдэг. Үг хэллэг бол сэтгүүлчдийн ажил үүргээ гүйцэтгэхэд ашигладаг хүчтэй хэрэгсэл ба хор хохирол учруулахаас зайлсхийх ёстой. Энэ нь ялангуяа сонгуулийн үеэр, улс төрийн нэр дэвшигчид заримдаа сэтгэл догдлуулам мэдэгдэл хийж, ихээхэн анхаарал татдаг тэр үед ихээхэн хамаатай.

Зайлсхийхийг хичээх нь:

- Яв цав бус, ялласан өнгө аястай, мөн ангуучлал, аллага, үй олноор хөнөөх гэх мэт мэдээлэл гэхээс илүү дэвэргэж хөөрөгдсөн үг хэллэгээс зайлсхийх. Улс төрийн нэр дэвшигчид хэрэв ийм үг хэллэг хэрэглэсэн бол баримт болгон мэдээлэхийн оронд тэдний үг гэж шууд ойлгуулах нь зүйтэй.
- Сурвалжлагчид мэдээ сурвалжлагадаа зандалчлагдсан, зэрэмдэглэгдсэн, цочирдсон гэх мэт дүрслэлийн үг хэллэгийг ашиглахаас зайлсхийх нь зүйтэй. Учир нь эдгээр нь өөрийгөө хохирогч гэж үзэж буй нэг талыг баримтласан хүний үг юм. Сурвалжлагч бол аль нэг талыг баримтлагч биш. Ийм үг хэллэгийг зөвхөн хэн нэгнээс иш татах маягаар хэрэглэвэл зохино.
- Хэсэг бүлэг хүмүүст террорист, бишрэн шүтэгч, туйлшрагч гэх мэтээр нэр хаяг зүүхээс зайлсхийх. Учир нь ингэх нь сурвалжлагчдийг ийм байр суурь илэрхийлэгч, эсвэл эмгэнэгч гэж ойлгуулна. Ийм хэсэг бүлгийг өөрсдийнх нь хэрэглэж, хэлж заншсанаар нэрлэ. Хэрэв улс төрийн нэр дэвшигчид иймэрхүү үг хэллэг ашиглавал баримт болгон мэдээлэхээс илүү шууд тэдний үг гэж ойлгуулах нь зүйтэй.

4.3. Сонгууль сурвалжлах олон улсын хэм хэмжээ

Дэлхий нийтийн ихэнх нь чөлөөт, шударга сонгуулийг тухайн орон ардчилсан, эсвэл ардчилалд шилжиж буй эсэхийг хамгийн чухал үзүүлэлт гэж тооцдог. Шударга гэдэг нь сонгуулийн кампанит ажил нь авлигаас хамгаалахын тулд хүн бүрт тэгш үйлчлэх дүрэм журамтай байхыг хэлнэ. Үүнээс гадна ардчилсан сонгуулийг бүрдүүлэхүйц төгс хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын хэм хэмжээ байхгүй. “Ардчилал, сонгуулийн тусалцааны хүрээлэн” (Institute for Democracy and Electoral Assistance)-гээс “Шийдвэр гаргах эрх мэдэл нь эцсийн эцэст, бүгдээрээ эрх тэгш иргэдийн хяналтад байдаг улс төрийн

тогтолцоо” хэмээн ардчиллыг тодорхойлсон хэдий ч энэ нь зарим тохиолдолд маргаантай үзэл баримтлал юм.

Гэхдээ сонгууль нь сонгох түгээмэл эрхийг баталгаажуулсан чөлөөтэй, шударга, тогтмол байх зарчмыг агуулна, санал хураалт нууц байна, албадлагаас ангид байна, “нэг хүн-нэг санал” гэсэн хүсэл үүрэг байна гэсэн хэм хэмжээг олон улсад хүлээн зөвшөөрсөн байдаг. 1946 оны Хүний эрхий түгээмэл тунхаглал, 1960-аад онд батлагдсан Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пактад ардчилсан сонгуулийн тодорхойлолтод эдгээр зарчмыг багтаасан байна. Түүнээс хойш энэ нь нийт иргэдийн шударга төлөөлөл байх, эрэгтэй, эмэгтэй хүмүүс эрх тэгш байх, мөн цөөнхийн эрх, эрхтэний бэрхшээлтэй иргэдийн талаар тусгай зүйл заалтыг хүлээн зөвшөөрсөн билээ.

Хуулиар дамжуулан ардчиллыг тогтоох Европын Зөвлөлөөс 2002 онд боловсруулан гаргасан “Сонгуулийн асуудлаарх шилдэг туршлагын зарчим”-д ардчилсан сонгууль нь түгээмэл, эрх тэгш, чөлөөт, нууц, шууд санал хураалт байх бөгөөд энэ нь тогтмол хугацаанд болно гэжээ.

- Түгээмэл гэдэг нь бүх иргэд сонгох, нас, оршин суугаа газар, мөн бусад үндэслэл бүхий хязгаарлалтаар сонгогдох хүнийг хайх эрхтэй болохыг хэлнэ
- Эрх тэгш гэдэг нь сонгогч бүр нэг саналын эрхтэй, суудлыг тэгш тоогоор тойргуудад хуваарилна, кампанит ажил, хэвлэл мэдээлэл нэр дэвшигч, намуудад эрх тэгш хүртээмжтэй байна, цөөнх мөн адил бөгөөд ялгаварлалаас ангид байна гэсэн үг юм.
- Чөлөөт гэдэг нь сонгогчид төрийн болон бусад хөндлөнгийн оролцоогүйгээр үзэл бодлоо баримтлах, намуудыг нээлттэй дэмжих, хориг саадгүйгээр, эрх тэгшээр мэдээлэл, санал хураах журам дүрмийг олж авахыг хэлнэ
- Нууц гэдэг нь санал хураах байранд сонгогчдын хувийн сонголтыг тэдний нэрстэй хэзээ ч илчлэхгүй гэсэн үг юм
- Шууд гэдэг нь хууль тогтоох этгээдийн үгүйдээ нэг танхим нь сонгогчдоос шууд сонгогдоно гэсэн үг юм.

Янз бүрийн оронд сонгогдсон нэр дэвшигчдэд суудал хуваарилах мажоритар, пропорционал, эсвэл холимог гэх мэт санал хураалтын үр дүнг илэрхийлэх янз бүрийн арга хэрэглэдэг. Түүнчлэн намын төлөө, эсвэл хүний төлөө саналаа өгөх, эсвэл сонгуулийн тойрог бүрээс хэд хэдэн төлөөллийг сонгох ч байдаг. Эдгээр арга, санал хураах тогтолцоо нь иргэдийн хүсэл тэмүүлэл, хүссэн хүлээлтийг шингээсэн, оролцооны, төлөөллийн, тайлагнах чадвартай, ил тод, хариуцлагатай сонгууль байж гэмээнэ ардчилсан болно гэж үздэг.

Гэсэн хэдий ч асуудлын гол нь ардчилсан сонгуулийн ийм зарчмыг сайшаахад бус, харин тэдгээрийг сонгуулийн кампанит ажлын үед дээд зэргээр жинхэнээр нь хэрэгжүүлэхэд оршино. Энэ бол хэдэн зуун зохицуулалт, дүрэм журамд тусгаж, кампанит ажлын үед шударгаар мөрдөхийг хүчилсэн, хожим нь сонгуулийн үр дүнг ардчилсан хэмээн зарлан тунхаглахыг тодорхойлох тийм үйл явц юм. Тэгээд ч энэхүү тунхаглалыг гагцхүү тухайн орон дотроо бус, олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс хүлээн зөвшөөрсөн байна. Олон улсын хамтын нийгэмлэг юу болсон, хэнтэй

харилцаж буй, ардчилалтай холбоотой олон улсын хэмжээг хүндэтгэсэн эсэхийг мэдэхийг хүсдэг. Үүний тулд НҮБ, Европын хамтын нийгэмлэг, Америкийн муж улсуудын холбоо, улс орны байгууллага, хувь хүмүүс тухайн орны сонгуулийг ажиглаж, ардчилсан шударга ёсонд нийцсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөхийн тулд туршлагад тулгуурлан боловсруулсан хөтөлбөрүүд байдаг юм. Сонгуулийн үеэр хэвлэл мэдээлэл хэрхэн ажилласан нь тэрхүү үнэлэлт дүгнэлтийн гол хэсэг болдог.

НҮБ-ын Сонгуулийн туслалцааны алба нь дэлхийн хэмжээнд сонгуулийн хамгийн том ажиглагч бөгөөд мэдээллийг www.un.org/Depts/dpa/ead/eadhome.htm цахим хуудаснаас авч болно. Сонгуулийн мониторингийн тухай, мөн мониторинг хийдэг байгууллагын тухай сайн мэдээлэл www.beyondintractability.org/essay/election_monitoring/ цахим хуудаст бий.

4.4. Суурь сэтгүүл зүй

Сэтгүүл зүйн мэргэжилтний хувьд өөрсдийн дадлага туршлагыг ашиглан хамт ажиллаж буй хүмүүстээ сурвалжлах анхан шатны ур чадварыг танилцуулах, сайжруулахад ашиглах олон аргыг зааварлагчид ашиглах болно. Сэтгүүл зүй, зааварчлах чадавхийн хувийн арга хэрэгсэл энд санал болгосноос илүү арвин байдаг. Ялангуяа хурцадмал зөрчил бүхий улс оронд сэтгүүл зүйн тодорхой нэг үзэл санаа, ур чадварыг хэрхэн, хэзээ нэвтрүүлэх вэ гэдгээ тодорхойлох нь зааварлагчдаас уян хатан байдал, бүтээлч ухаан шаардана. Энд дурдсан зүйлүүд нь өөрийн нөхцөл байдалд юу хийх зохилтойг эргэн сануулах, чиг хандлагаа тодорхойлоход зориулагдсан гарт буй арга хэрэгсэл гэж болох юм. Суурь сэтгүүл зүйн ур чадварын хэсэг нь мэдээ бэлтгэхдээ тунгаан бодох, арга барил, учир уялдааны арга хэрэгсэл гэсэн гурван ангилалд хуваагдана.

4.4.1. Мэдээ бэлтгэхдээ тунгаан бодох нь, ур чадвар

Мэдээ гэж юу вэ?

Мэдээ гэж хүмүүсийн ярьдаг зүйл юм. Мэдээ бол өөрчлөлт, эсвэл шинэ зүйл, аюул занал, эсвэл алдартай хүмүүсийн тухай мэдээлэл. Мэдээ гэж хүмүүсийг асуухад хүргэдэг зүйл юм. “Гол гудамжинд юу болсоныг сонссон уу? Цагдаа хүн бүрийг зогсоож байна гэсэн. Яагаад?” “Тэд гэмт этгээдийг баривчлах гэж оролдож байгаа гэж би сонссон”. Эсвэл “Бензиний үнэ дахиад нэмэгдэж байгааг сонссон уу?”, эсвэл “Хөөе! 55 хүн Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихээр бүртгүүлсэн байна”, “Тийм гэнэ ээ. Би тэдний талаас илүүгийнх нь тухай сонсоо ч үгүй юм байна. Тийм олон хүнээс бид яаж сонголтоо хийх болж байна аа?”

Ихэнх хүмүүсийн хувьд, тухайлбал энэ нь тэдний гудамжинд, өөрсдийнх нь хүй олны дунд, өөрсдийнх нь хотод, өөрсдийнх нь улсад болсон явдлын тухай мэдээ тэдэнд онцгой нөлөө үзүүлдэг. Айдас (догшин шуурга), үхэл (Иракт нэг өдөр 150 хүн алагдсан), аврал (Айр Франсын онгоц Торонто хотноо сүйрч, бүгд амьд үлдсэн) гэх мэт түгээмэл үнэт зүйлсийн тухай л биш бол ихэнх хүмүүс өөрөөс нь хол болсон зүйлд сонирхол багатай байдаг.

Мэдээг радио, телевиз, интернэт, тэрчлэн ам дамжуулан сонсдог. Тэгвэл яаж бий болдог вэ? Мэдээг сэтгүүлч, сурвалжлагч, продюсерүүд гадуур явж, эрж хайдаг. Учир

нь хүмүүс мэдээний үнэ цэнийг хэрхэн үнэлдгийг тэд мэддэг. Юу болж байгаа, мөн юу тэдний амьдралд нөлөөлж болох тухай мэдээллийг хүргэнэ гэж хүлээдэг учраас хүмүүс мэдээ хүргэж буй хэвлэл мэдээлэлд ханддаг.

Мэдээний түүх гэж юу вэ?

Суурь сэтгүүл зүй түүх өгүүлдэг. Энэ бол та найз нөхөртэйгээ, эсвэл гэр бүлийнхээ хэн нэгэнтэй ярихдаа юу болсон, юу болох гэж буй тухай тодорхой, нээлттэй ярилцдагтай адил хэрэг. Та мөн энэ юу гэсэн үг вэ, яагаад гэдэг тухай ярьдаг. Товчхон хэлэхэд, суурь сэтгүүл бол мэдээлэл агуулсан харилцан яриа юм.

Сайн түүх Хэн? Хэрхэн? Юу? Хаана? Хэзээ? Яагаад? гэсэн асуултад хариулна. Сонгууль сурвалжлахад эдгээр асуулт нь мэдээний түүхийн үндсэн агуулгыг тодорхойлоход тусална. Нэр дэвшигч хэн бэ, аль намын хүн бэ? Тэр юу амалж байна вэ? Амлалтаа хэрхэн биелүүлэх гэж байна? Тэр амлалтдаа хэзээ хүрэх вэ? Нэр дэвшигчийн кампанит ажлыг хэн санхүүжүүлж байгаа вэ? Ялалт байгуулсан цагт энэ нь шийдвэрт хэрхэн нөлөөлөх бол? Гэхдээ энэ мэдээллийг илүү утга учиртай болгохын тулд мэдээний түүх бусад нэр дэвшигч тухайн ижил асуултад хэрхэн хариулснаас иш татах нь зүйтэй. Түүх бүхнийг тэнцвэртэй бэлтгэх боломжгүй ч гэсэн хэд хэдэн түүхийн эцэст шударга, эсвэл төлөөлөл тэнцвэртэй байх ёстой.

Хариуцлага

Сонгууль бол сурвалжлагын бусад төрөлтэй адил. Сурвалжлага мэргэжлийн сэтгүүл зүйд хариуцлага ногдуулдаг. Энэ нь эх сурвалж нэрээ хэлэх боломжгүй бол нууцална гэсэн үг. Энэ нь мэдээ олж авахын тулд гагцхүү чин шударга, хууль ёсны арга хэрэглэнэ гэсэн үг. Энэ бол хаа нэгтэйгээс тайлагнасан баримт сэлтийг шалгахгүйгээр мэдээлж сурвалжлагаас зайлсхийнэ гэсэн үг.

Сонгуулийн кампанит ажлын үеэр ч гэсэн сэтгүүл зүй нь хариулт, эсвэл тайлбаргүйгээр хэн нэгнийг мэдсээр байж, дахин дахин нягт нямбай бусаар яллах, доромжлон гомдоохыг үл зөвшөөрнө. Энэ нь сонгуулийг ардчилсан болгож, сайн мэдээлэл бүхий сонгогчдыг чөлөөтэй сэтгэхэд тусална.

Нягт нямбай байх нь

Нэр дэвшигчийн нэрийг бичихдээ нягт нямбай байхаас гадна дүрслэх, иш татах, уг санааг тайлбарлахдаа ч аливаа хэтрүүлэлгүйгээр зохих түвшинд хандах. Хэрэв та хүмүүс, газар нутаг, үйл явдлын тухайд нягт нямбай бус өгүүлбэл, хүмүүсийг төөрөгдүүлнэ. Таны эхний сурвалжлага нягт нямбай бус болж гэдгийг хүмүүс мэдвэл бүр муу. Бусад мэдээлэл нь зөв байсан ч хүмүүс танд итгэхээ болино. Тэд тантай ярихаа ч болино.

Мэргэжлийн сурвалжлагчид нягт нямбай байх нь бүх зүйл дүрмийн алдаагүй, зөв байхаас эхэлдэг гэдгийг мэднэ. Толь бичиг ашигла, эсвэл компьютер дээрээ дүрмийн программ суулгах нь зүйтэй. Радио, телевизэд зориулан бичсэн ч гэсэн зохиолд зөв бичигдсэн зүйл зөв дуудагддаг гэдгийг санахад илүүдэхгүй.

Шударга, тэнцвэртэй түүх

Сонгуулийг шударга, тэнцвэртэй сурвалжилна гэдэг нь тухайн нэг түүх, тодорхой цаг

хугацаанд гарах хэд хэдэн түүхийн загвар, янз бүрийн нам, нэр дэвшигчдийн санаа бодлыг агуулах гэсэн үг юм. Нэр дэвшигч бүр, нам бүрийг нэг түүхэд багтаах аргагүй. Гэхдээ мэргэжлийн сурвалжлагчид аль нэг нэр дэвшигчийг илүүд үздэггүй. Тэд бол ердөө л олон нийтэд асуудлыг олон талаас нь ойлгуулахад зориулан хүмүүсийн өмнөөс асуулт асууж, хариултыг харьцуулж, янз бүрийн санаа бодлыг толилуулах, тайлбарлах, мөн суурь мэдээлэл, эх санааг нэмж тайлбарлах ажил хийдэг.

Тэнцвэртэй байх гэдэг зөвхөн найрсаг хандахаас илүү зүйл юм. Энэ нь, ялангуяа нэр дэвшигчид кампанит ажлын үеэр бие биенээ байнга буруутгаж байгаа бол зайлшгүй хэрэгтэй зүйл. Бусдынх нь хариулт, хариу үйлдлийг мэдэж олоогүй цагт аль нэг талыг яллах, доромжлох мэдээлэл бүү тараа. Танд бол нэр дэвшигч А нэр дэвшигч Б-гийн тухай ингэж ярьж байна гэж хэлэхийг л зөвшөөрнө. Гэхдээ нэр дэвшигч Б-тэй ярилцах бүх боломжоо шавхан, яллаж буй зүйлд өөрөө хэрхэн хандаж буйг тодруулахыг зорих ёстой. Тэнцвэртэй байдал гэж үүнийг хэлнэ.

Иш татах

Мэдээний түүхэд мэдээлэл оруулахдаа та эх сурвалжийг нэрлэх, эсвэл иш татах ёстой. Жишээ нь, “Цэнхэр тэнгэр” намын Жаки Файпамал “Хэрэв сонгогдвол бензиний үнийг бууруулна” гэжээ. Мэдээнд үүнийг мэдээлэхдээ чухам тэр ингэж хэлсэн гэдгийг цохон хэлэх нь чухал. Ингэвэл уншигч, сонсогч, үзэгчид сурвалжлагч өөрөө үүнийг хэлээгүйг мэдэх болно. Хэрэв уншигч, сонсогч, үзэгчид тухайн сурвалжлагатай санал нийлэхгүй байвал сурвалжлагчид бус, харин хэнд хандан гомдол гаргахаа мэдэх болно.

Эх сурвалжаа хамгаалах үүрэг хариуцлага

Эх сурвалж сэтгүүлчид хандан ач холбогдол бүхий зүйл хэлэх, ингэхдээ нэрээ нууцлахыг хүсвэл сэтгүүл эх сурвалжийнхаа нэрийг ИЛЧЛЭХГҮЙ байх үүрэг хариуцлага хүлээнэ. Энэ нь хэвлэл мэдээлэлд хаа нэгтэйгээс олж мэдэж үл болох мэдээллийг эх сурвалжаас авах боломж олгодог сэтгүүлчийн үүрэг хариуцлагын дагуу хүлээсэн итгэл юм.

Гэхдээ эх сурвалжаа хамгаалах нь нягт нямбай байх, шударга, тэнцвэртэй байхыг эрмэлзээгүйгийн улмаас цуурхал, хэн нэгнийг буруутгасан тухай мэдээлэхийг зөвшөөрч, уучилна гэсэн үг биш.

4.4.2. Арга барил

Асуулт тавих

Сурвалжлагчид цаг ямагт асуулт тавьдаг боловч, ихийг хэлсэн хариулт авах нь цөөнгүй. Нээлттэй төгсгөл бүхий асуулт тавих нь хэрэгтэй, мэдээлэл агуулсан хариулт авах арга юм. Ийм асуултад ердөө л “тийм”, эсвэл “үгүй” хэмээн харилцан ярилцахад төгсөл тавьсан хариулт өгөх боломжгүй. Нээлттэй төгсгөл бүхий асуулт нь нэр дэвшигчийг бодох, бүрэн хариулахаас аргагйд хүргэдэг. Ийм асуулт “юу”, “яагаад”, эсвэл “хэрхэн” гэсэн үгээс эхэлнэ. Эдгээр нь нэр дэвшигчийг тайлбар өгөхөөс аргагүй байдалд оруулна. Түгээгч нь чадахгүй байгаа тохиолдолд та бензиний үнийг хэрхэн бууруулна гэж бодож байна? Түлшний үнийн татаасыг яаж хийх вэ? Үүнийг хийх хөрөнгийг хаанаас гаргах вэ? Түгээгчид үнээ бууруулахгүй бол та юу хийх вэ? Энэ

асуултууд улс төрчөөс нээлттэй байх, үг, өгүүлбэрээ сонгохыг шаардана.

Тодорхой байх

Шууд, товчхон иш татахаас өөр зүйл бол сэтгүүлчид мэдээнд өөрийнхөө үгийг ашигладаг. Нэр дэвшигчдийн урт, ээдрээтэй, эсвэл бултах өнгө аястай мэдэгдлүүдийг боловсролын түвшин харилцан адилгүй уншигч, сонсогч, үзэгчдэд ойлгогдохоор энгийн болгож, “хөрвүүлэх” нь сэтгүүлчийн ур чадварын нэг хэсэг юм. Нэр дэвшигчийн хэлсэн тодорхой бус бол түүнийг нь харуулна. Өөрөөр хэлбэл, өөрийн ойлгоогүй, илүү тодорхой болгон тайлбарлаж үл чадах зүйлийг давтахын хэрэггүй.

Үг нь том, өгүүлбэр нь урт байх тусам таны мэдээ ойлгомжгүй болдог. Та энгийн үг хэрэглэвэл илүү ойлгомжтой байх болно.

Хувийн үзэл бодол

Мэдээ бэлтгэхдээ сэтгүүлчид өөрийн үзэл бодлыг сонгуулийн сурвалжлагад оруулж үл болно. Уг болж байгаа тухай мэдээлэл сонсохын тулд олон нийт танаас хамааралтай болдог. Нэр дэвшигчийг, түүний санаа сайхан санагдах эсэх нь зөвхөн таны шийдэх хэрэг биш юм.

Юунаас зайлсхийх вэ?

Сэтгүүлчид улс төрийн нам, нэр дэвшигчдээс бэлэг гэж хэлсэн ч юу ч авч болохгүй. Тэр бүү хэл нэр дэвшигчдийн унааг ч ашиглаж үл болно. Ганц нэгээрээ нэр дэвшигчидтэй хамт аялснаас сэтгүүлчид нийлээд, хувийн унаа хөлслөн, үнээ хуваан төлсөн нь хавьгүй илүү бөгөөд ухаалаг. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хамтран ажлын хөлс, тээвэр, буудлын зардлаа хуваан даавал сурвалжлагчид нь бие даан ажил үүргээ нэр төртэй, бусдын нөлөөнд автахгүйгээр гүйцэтгэх боломж олгоно.

Иргэн хүнд хувьд нь зориулан сурвалжлах нь

Сонин хэвлэл, бусад төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн алинд нь ажиллаж байгаагаас үл хамааран сэтгүүлч хүний хувьд та хувь хүнтэй хүүрнэж байна гэдгээ санаж байх ёстой. Мэдээ, сурвалжлага нь тодорхой байхын тулд, мэргэжлийн сэтгүүлчид нь тодорхой байж, өөрийн таньдаг хүнийхээ талаар бодож, түүнтэй хүүрнэж байна, түүний төлөө бичиж байна хэмээн төсөөлөх хэрэгтэй.

Заль мэх

Улс төрийн нэр дэвшигчид хэвлэл мэдээллийг өөрийн илгээлтийг хүмүүст хүргэхийн тулд ашиглахыг оролдох тул сэтгүүлчид гагцхүү баримт сэлт цуглуулахаас гадна өөрсдийг нь залилан мэхлэх оролдлогод сонор сэрэмжтэй хандах хэрэгтэй. Улс төрчид эерэг харагдахын тулд байнга шинэ, шинэлэг, эрч хүчтэй, довтолсон, нэвт ухаарсан шинжтэй, дэвшилтэт, тэгширсэн үг хэллэг хэрэглэдэг. Өөрсдийнх нь хэлж буй зүйл сонгогчдын сэтгэлд нийцээсэй гэсэндээ тэд эдгээр үг хэллэгийг ашигладаг. Улс төрчдийн хэлснийг иш татахаас бусад тохиолдолд сурвалжлагчид тэдгээр үгсийг давтах ёсгүй.

Нэр дэвшигчид илүү байдал олгохыг тулд тэд, тэдний туслагчид мэдээ гэж юу болохыг зааж сургах гэж оролдоно. Эсвэл мэдээг өөрийнхөө тайлбарт нийцүүлэх гэж санал хэлдэг. Үүнийг “эргүүлэлт” гэж нэрлэдэг. Шударга тэнцвэртэй байдлын төлөө бусад нэр

дэвшигчийн үзэл бодлыг сонсох, эсрэг “сөрөг эргүүлэлт” хийх нь чухал. Гэхдээ сурвалжлагчид өөрсдийнхөө тухай бодох нь дээр. “Эргүүлэлт”-д найдахаасаа илүү сонгогчдоос тэд юу бодож буй тухай асууж, шинжээчдийн үзэл бодлыг сонссон нь дээр.

Ялангуяа кампанит ажлын үед, олон нийтэд аль болох тодорхой, хэт өндөрт тавиагүй мэдээ түгээхийн тулд сэтгүүлчид тодруулга хүсэх үүрэг хариуцлага ногддог. Нэр дэвшигч хэрэв шинэ хөтөлбөр санал болгож буй бол урьд өмнөх хөтөлбөрөөс юугаараа ялгаатайг тодруулж асуу. Энэ хөтөлбөрийн зорилтод хэрхэн хүрэх гэж төлөвлөж буйг тодруул.

Сэтгүүлч нарийвчилсан зүйл асууж, нэр дэвшигчээс мэдээллийг гадагшуулах үүрэгтэй. Хэрэв нэр дэвшигч нарийвчилсан зүйлийн тухай удахгүй мэдээлнэ, эсвэл одоохондоо нарийвчилсан төлөвлөгөө гараагүй байгаа гэвэл кампанит ажлын амлалт хоосон урнаар өгүүлэхүй биш биз гэдгийг сэтгүүлч тодруулах ёстой. Ухаалаг асуултаар үүнийг тодруулж болно. “Зорилтдоо хэрхэн хүрэхээ мэдэхгүй байж, та яаж амлалт өгч чадаж байгаа юм бэ?” Таны санал болгож буй төлөвлөөнд нарийвчилсан зүйл алга байхад сонгогчид яагаад таны төлөө саналаа өгөх гэж?”, “Таны төлөвлөгөө биднийг өнгөрсөн оны хямралаас хэрхэн гаргах вэ?”

Ард түмний нэрийн өмнөөс ярьж байна хэмээн нотолж буй нэр дэвшигчдийг таньж мэд. Хэрэв нэр дэвшигч: “Ард түмний ихэнх нь энэ хуулийг өөрчлөхийг хүсэж байна” гэвэл сурвалжлагч “Та яаж мэдэж байгаа юм бэ? Ямар санал асуулгыг үндэслэж байна вэ? Судалгаагаар үүнийг дэмжиж байна гэсэн үү?” гэж асуух нь зүйтэй.

Сурвалжлагчид сүрдүүлгээс зайлсхийх ёстой. Мэдээ сурвалжлагад нөлөөлөхийн тулд зарим нэр дэвшигчийн туслахууд сурвалжлагчийг айлган сүрдүүлэхийг оролдож магад. Боломжтой бол гэрчүүдийн нүдэн дээр сүрдүүлгийн бичлэгийг хийж, мэдээндээ оруулахыг хичээгээрэй. Энэ нь боломжгүй, эсвэл хэтэрхий аюултай, айлган сүрдүүлэлтийн тухай редактор, эрхлэгчдээ цаг үргэлж дуулгаж бай. Ер нь бол сурвалжлагчид ийм сүрдүүлгийн тухай мэдээндээ үргэлж мэдээлж байх нь зүйтэй бөгөөд ийм сүрдүүлгийн оролдлогыг илчилж байвал зохино.

Ярилцлага хийх урлаг

Сонин хэвлэл, электрон хэвлэл мэдээллийн хэрэгслийн алиных нь ч хувьд, ярилцлага бол сэтгүүлч, нэр дэвшигч, эсвэл эх сурвалжийн хоорондын хэлэлцээрийн үйл явц юм. Энэ бол нэр дэвшигчээс аль болох их хэмжээний мэдээллийг илрүүлэх тухай тохиролцоонд аажимдаа хүрэх тухай асуудал юм. Сэтгүүлч ямар нэг этгээдийн хувьд бус харин хүний хувьд нэр дэвшигч, эх сурвалж, зочин, алдартныг сайн сонсох ёстой төдийгүй тэдэнд олон нийттэй мэдээллээ хуваалцахыг хөхиүлэн дэмжих ёстой.

Хамгийн амжилттай ярилцлага үндсэн дөрвөн зарчимд тулгуурладаг. Үүнд:

- 1) Ярилцлага авахын өмнө тэр юуны тухай сайн мэддэгийг олж мэд
- 2) Ярилцлагыг яах гэж хийх гэж буй, тухайлбал ямар мэдээлэл, түүх, эсвэл нотолгоо олж авах гэж буйгаа мэд
- 3) Ярилцлага бүхэнд тэгш талуудын хоорондын харилцан яриа гэж хандах, мөн нэр дэвшигчдэд адил тэгш харилцах

- 4) Асуулт, хариулт аль хэр хүнд, зөрчилдөөнтэй санагдахаас үл хамааран хүний эрхэм чанар, эсвэл итгэлд тулгуурлах. Хамгийн адгийн амьтан байсан ч өөрийн санаа бодлыг олон нийтэд сонордуулах завшаан тохиодог. Ярилцагчдын хэн хэн нь хүндэтгэл, итгэл төрүүлэхүйц, нэр төртэй хариулт өгөх зориг гаргахуйц тийм тодорхой, нэр төртэй асуулт олж тавих нь сэтгүүлчийн хэрэг юм.

Ярилцлагын үед:

- 1) Ярианд анхаарал сайн хандуул
- 2) Онцгой нарийвчлан асуулт тавихдаа бэлэн байх
- 3) Сониучирхан ярианд татагдан орж буй гэдгээ ярилцагчдаа ойлгуулахаар суу. Суудал дээрээ бүү хавчигна, бүү эргэлд, бас бүү хайвгана.
- 4) Ойлгомжгүй ямар нэг зүйл гарвал алгуурлалгүй асууж тодруул. Ярилцагч санаандгүй маш сонирхолтой зүйл хэлбэл аль болох олон асуултыг алгуурлалгүй асуу. Бүү хүлээ. Үл ойлголцлыг, эсвэл сонирхолтой материалыг сорьж шалгахын тулд шуурхай хариу үйлдэл хий.
- 5) Ярилцагчтайгаа нүдээрээ харилцаж, ойлгож буйгаа толгойгоо алгуурхан дохин харуул. Гэхдээ найрсаг байдал бий болсон үед л ингэх нь зөв.

Ярилцлагын үед хийх ЁСГҮЙ:

- 1) Нэг дор хоёр буюу түүнээс дээш асуулт бүү тавь. Хэрэв та: “Та ноён ABC-тэй ямар харилцаатай, түүнд эрх мэдэлдээ эргэж хүрэх боломж бий болов уу?” гэж асуувал нэр дэвшигч хоёр асуултад хэсэгчлэн хариулах магадлал өндөр. Учир нь энэ бол сүүлчийн асуулт, хариулахад амархан.
- 2) Хөтлөх асуулт бүү тавь. Ийм асуулт сэтгүүлчийн зөв, зочны буруу гэсэн сэтгэгдэл төрүүлдэг. Энэ нь “Та тэгж бодоогүй гэж үү?”, “Та тэгэх ёсгүй байсан биш үү?” гэх мэт асуулт юм
- 3) Үзэл бодлоо асуултдаа бүү оруул. Ингэх нь мэдээллийн чухал урсгалыг зогсоож, нэр дэвшигчийг өөр ямар нэг зүйлийн тухай ярихад хүргэнэ.
- 4) Тулгах асуулт бүү тавь. “Тэр, тухайлбал XYZ яаж Ерөнхийлөгчөөр сонгогдож чадав аа?” XYZ тохирохгүй байсан гэх аястай тулгасан асуулт нь нэр дэвшигчийн бодолтой нийлэхгүй байж болно. Эсвэл нэр дэвшигч хамгаалалт хийж, мэдээллийг дарагдуулж болзошгүй. Түүний оронд “XYZ сонгогдсоныг та юу гэж бодож байна?” гэж асуу.
- 5) Өдсөн, эсвэл эмзэглэмээр үг агуулсан асуулт бүү тавь. “Хуучинсаг үзэлтний хувьд, та яагаад ...?” гэх нь ярилцлагыг тасалдуулахад хүргэнэ. Зочин тантай “Хуучинсаг үзэлтэн” гэдэг үгийг талаар маргаж, өөрсдийн байр суурийг хамгаалж эхлэх бөгөөд та өөрийн асуултад хариулт авах боломжоо алдлаа гэсэн үг.
- 6) Туйлширсан өнгө аястай үг асуултдаа бүү хэрэглэ. “Гадил намтай хийсэн уулзалт аль хэр санагдав?” гэхийн оронд “Гадил намтай хийсэн уулзалтын тухай та юу бодож байна?” гэсэн нь дээр. Сайн ярилцлага авагч бол туйлын төвийг сахисан, өөрийн тухай үл өгүүлж, нэр дэвшигчийг сайн нээдэг.
- 7) Хэтэрхий урт асуулт бүү тавь. Богино асуулт тодорхой, тодорхой хариулт шаарддаг, бултах боломж олгодоггүй.

Нягтлах нь

Нягтална гэдэг олон нийтэд хүрэхийн өмнө мэдээ хэрхэн уншигдаж буй, сонсогдож буйг нягтална гэсэн үг юм. Редакцидаа байгаа хэн нэгнийг олон нийтийг төлөөлж мэдээгээ унших, эсвэл өөрөө уншиж байхад чинь сонсохыг гуй. Олон нийтийг төлөөлөгч, дараа нь “Энэ хэсэг тодорхой бус байна. Өөрөөр сайн хэлэх арга байна уу?”, эсвэл “Энэ өгүүлбэр жаахан чанга/сул байна. Үнэхээр ийм явдал болсон уу? эсвэл “Нэр дэвшигч юу хэлэх гэсэн юм бол?” гэх мэтээр тодруулга шаардана.

Эсвэл зүгээр л үзэг нэгт нөхөртөө хандан: “Хөөе, энэ талаар чи юу бодож байна?” гэж асуун, мэдээгээ нягтлан шалгаж болно. Энэ нь цаг авахгүй, ердөө хэдэн минут зарцуулах боловч сэтгүүлчид бие биедээ туслахын үр дүн нь илүү сайн мэдээ бэлтгэхэд тусална. Ингэх нь хүн бүрт ашиг тустай.

Редакцийн уулзалт

Мэдээний редакцид ажиллаж буй сурвалжлагч, продюсер, редактор сонин хэвлэл, электрон ХМХ алинд нь ажиллаж байгаагаас үл хамааран өдөр бүр ажилдаа ирэхдээ өнөөдөр юуны тухай мэдээ сурвалжлага бэлтгэх вэ гэсэн өөрийн санаатай байвал зохино. Санаа сонины өгүүлэл, сэтгүүл, телевиз, мэдээний үйчилгээний алба, өөрийн үзсэн, сонссон зүйлс, эх сурвалж, хэвлэлийн мэдээ, өрнөж буй нөхцөл байдал, ер нь илүү ихийг олж мэдэх сониуч зан хөдөлгөсөн ямар ч зүйлээс төрж болно. Сурвалжлагчид энэ санааныхаа тухай ярих, бусадтайгаа хуваалцах, мэтгэлцэхэд бэлэн байвал зохино. Түүнчлэн, бүх сэтгүүлч, эсвэл редактор, менежерүүд өглөө эрт цуглан тухайн өдрийн редакцийн өгүүлэл, мэдээний тухай төлөвлөх нь зүйтэй.

Уулзалтыг удирдах нь

Уулзалт дээр хүн бүр шилдэг санаагаа танилцуулж, бусад нь асууж хэлэлцэхэд санаагаа хамгаална. Санааг зөвхөн асуудал төдий бус түүх маягаар танилцуулдаг. Жишээ нь, гэмт хэргийн асуудал бол “Хүй олны зарим удирдагч учраас цагдаа уруу утасдахаас айдаг болохыг би мэднэ” гэсэн түүх байна. Ийм түүхийн жагсаалтыг түргэн гаргаж, өнөөдөр аль нь хамгийн чухал болохыг бүгдээрээ тохиролцоно. Уулзалтыг удирдан явуулж буй ахлах редактор, эсвэл менежер тухайн түүхийг санал болгосон хүнийг томилж, мэдээгээ бэлтгэхийг зөвшөөрдөг. Сонирхол арай бага татсан санааг дараагийн удаад ашиглахаар хадгална. Шинэ санаа гарч ирэхийн хэрээр ашиглаагүй санааг жагсаалтаас хасна.

Редакцийн уулзалт дээр яригдах зүйл:

- Яагаад энэ түүх чиний сонирхлыг татсан бэ? Яагаад би энэ тухай санаа зовних учиртай вэ?
- Яагаад заавал өнөөдөр гэж?
- Энэ түүхийн сэтгэл арзагануулж буй зүйл нь юу вэ?
- Энэ нь сонсогчдод хэрхэн туслах вэ? Энэ хүмүүсийн хүсэж буй зүйл мөн үү?
- Үүний тухай бид өмнө нь дуугарсан уу? Юу нь шинэлэг юм бэ?
- Энэ санаа хэтэрхий хөнгөн, эсвэл үзүүлбэр (шоу) маягтай юм биш биз?
- Энэ тухай хэн ярьж чадах вэ?
- Энэ талаар хэн өөр санаа бодолтой вэ?
- Ийм түүхийг бид хэрхэн сурвалжлах вэ?

- Энэ түүхийг бид утсаар ярилцаж, өөртэй нь уулзан ярилцаж, эсвэл товч намтар маягаар, эсвэл өөр хэлбэрээр хийх үү? Энэ түүхийн жинхэнэ уг утга санаа, суурь төлөв байдлыг бид хэрхэн гаргах вэ?
- Илүүдүүлсэн, хэтрүүлсэн зүйл байна уу? Юу дутуу байна вэ?

Уулзалт хөгжүүн, цагаа барьсан байхаас гадна гол төлөв 40 минутаас хэтрэхгүй байдаг.

Түүх бэлтгэх даалгавар

Сайн сурвалжлагчийн хийх анхны алхам нь түүх болж өнгөрсөн цаг, байршлыг тогтооно. Тэнд хэн хэн байх нь вэ, нэгээс илүү ярилцлага авах шаардлагатай эсэхийг олж мэдэх хэрэгтэй болдог. Эрт оч. Хүн бүрээс мэдээлэл цуглуул. Даалгаврынхаа цагаас хожимддог сурвалжлагч өөр ажил хайсан нь дээр байх.

4.4.3. Зохион байгуулалт ба арга барил

Ярилцлага товлох

Тэмдэглэл хөтлөх цаг хугацаа давчуу үед тухайн сэдвийн талаар сайн мэдлэгтэй хүн бүр сайн ярилцлага өгөх чадвартай байдаггүйг санах хэрэгтэй. Тэд бас радио, телевизэд ярилцлага өгөхдөө маруухан байдаг. Иймээс ярилцлага авах гэж буй хүнээ бэлдэх шаардлагатай.

Ярилцлагын товыг тохирохдоо өөрийнхөө хэн болох, ямар учраас ярьж буй, ямар мэдээлэл хайж буйгаа тайлбарлах учиртай. Ярилцлага авахыг хүсэж буй чухам тэр хүн чинь мөн байна гэсэн шийдвэр гаргахаасаа өмнө хэд хэдэн урьдчилсан асуулт тавих нь зүйтэй. Тодорхой мэдээллийн сайн эх сурвалж бол өөр хүн байж болох нь анзаарагдаж болно шүү дээ.

Хэрэв радио, телевизэд ярилцлага авах гэж буй бол товлогдсон цаг, байршил, ярилцлагын хугацаа зэргийг тэр хүн чинь ойлгосон байвал зохино. Мөн биеэр уулзаж ярилцах уу, эсвэл шууд ярилцлага уу, өмнө нь бичлэг хийх үү, эсвэл мэтгэлцээний хэсэгт багтах уу зэрэг тохиролцсон зүйлийн тухай хэлж өгөх нь чухал. Ярилцлага хийх хүмүүсийнхээ утасны дугаар, нэр ус нь зөв эсэхийг магадлах ёстой. Түүнчлэн, ярилцлага, хөтөлбөрийн төгсгөлд оруулж болохоор сонирхолтой зүйлийн тухай нарийвчлан мэдсэн байвал зохино. Сонин хэвлэл, электрон ХМХ алинд ч ажилладаг байсан, хугацаа нь өөрчлөгдөж болзошгүй тул ярилцлага хийх хүмүүстээ өөрийн утсыг өгсөн байх шаардлагатай.

Шинэ зай, удаан ой санамж

Сонин хэвлэл, радиогийн сурвалжлагчид ажлаасаа гарахын өмнө бичлэгийн хураагуур, цахим хураагууртаа шинэ зай хийсэн эсэхээ шалга. Хэд хэдэн зай давхар авч гар. Цахим хураагуурын зай хурдан дуусдаг. Хэд хэдэн ярилцлага хийхээр явж буй бол мини дискээ нөөцөлж ав. Хуурцаг, мини диск дээрээ агуулгаа тэмдэглэхээ мартуузай.

Телевизийн хувьд, зай, гэрэл, микрофон, хөл зэрэг зураглаачийнхаа хүнд ачаанаас хөнгөлж, заримыг өөрөө үүрэх нь зүйтэй. Зураглаачдаа зай, хальс, диск, микрофоны утас, бусад хэрэгтэй зүйлээ нөөцөлж, илүү авч гарахыг сануулаарай.

Газар дээрээс сурвалжлах

Томилолтоор яваа сурвалжлагчид гар утастай байх шаардлагатай. Газар дээрээ очсоны дараа томилолт, ярилцлагад нэмэр болохуйц нэмэлт мэдээлэл, мэдээ байгаа талаар редактор руугаа утасдаж лавлах нь зүйтэй. Мөн мэдээлэл цуглуулж, ярилцлагаа дууссаны дараа, эсвэл түүх өөрчлөгдөхөд хүрвэл редактор, менежер руу утасдвал зохино.

Радиогийн сурвалжлагчид нэвтрүүлэх танхим, нам гүм орчинд бичлэг хийхээс бусад газар бичлэг хийхдээ түвшинг тохируулах, мөн ямар нэг саад учрахаас сэргийлэн чихэвчээ зүүх шаардлагатай.

Шууд нэвтрүүлэг хийх үед сурвалжлагчид радиогийнхаа хөтлөгчтэй утсаар холбогдох шаардлагатай бол тоног төхөөрөмжөө урьдчилан тохирсон байна. Мөн хөтлөгчөөс сурвалжлагчид тавих хэд хэдэн асуулт, тухай бүр өөрөө ярьж дууссанаа илтгэх “Хөтлөгчид хандая” гэх мэт үгсийг урьдчилан тохирсон байх ёстой. Түүнчлэн ярилцаж буй, эсвэл хэлсэн үгнээс нь иш татах хүнийхээ албан тушаалыг өөртөө зөв бичиж тэмдэглэсэн байна.

Амьд, тодорхой мэдээ туурвих нь

Сэтгүүлчдийн зарим нь мэдээлэл цуглуулдаг. Нөгөө хэсэг нь мэдээ туурвиж, уншигч, сонсогч, үзэгчийн анхаарлыг татаж, сонирхлыг төрүүлж, ямар нэг зүйлийг сурч мэдэхүйц түвшинд сайн түүх өгүүлж, туурвидаг. Сайн сурвалжлагчид бол түүхийг сайн өгүүлэгчид юм.

Радиогийн сурвалжлагчдын хувьд бол энэ нь ямагт хүнээ танилцуулах арга барил юм. Клипт дуу хоолойг оруулахын өмнө хүний сүүлчийн хоёр өгүүлбэрийг хэрхэн багтаах тухай асуудал. Клипийг 40 секундээс хэтрүүлэх хэрэггүй. Богино байх тусмаа илүү сайн. Сонсогчид радио сонсож байхдаа гол төлөв өөр юм хийж байдаг тул урт клипийн учрыг төдийлөн олдоггүй.

Үүний нэгэн адил сонин, сэтгүүлийн сурвалжлагчид иш татахдаа уртаас богиныг илүүд үзэх нь зүйтэй. Ихэнх хүмүүс уншигчдын хүсээд буй товчхон, базсан мэдээлэл өгөхөд суралцаагүй байдаг. Нэр дэвшигчийн хэлсэн үгнээс иш татахад хэтэрхий урт байвал түүний хэлсний мөн чанарыг хадгалан өөрийн үгээр товчлох шаардлагатай.

Нэр дэвшигчийг хүссэнээр яриулаад байх тийм индэр бий болгох нь сэтгүүлчийн үүрэг биш. Сонсогчид тухайн түүхийг илүү сайн ойлгуулахын тулд нэр дэвшигчийн хэлснээс өлгөн зөв иш татах, эсвэл клипийн хэмжээг тохиромжтой болгох нь сэтгүүлчийн ажил юм.

Сурвалжлагчийн ажил бол зөвхөн давтах бус мэдээлж сурвалжлах юм.

4.5. Сонгуулийн сурвалжлагыг төлөвлөх нь

Сонгууль сурвалжлах төлөвлөгөө кампанит ажил эхлэхээс өмнө боловсруулах нь чухал. Үйл явдалд хариу үйлдэл хийхээс урьдчилан төлөвлөж, юуг тусгах вэ гэдгээ тодорхойлох нь хавьгүй дээр. Үгүй бол, доргиосон үйл явдал зохиож буй нам, нэр

дэвшигч таны анхаарлыг цаг ямагт татаж, зөвхөн доргисон учраас л мэдээ болно. Төлөвлөгөө хийхдээ туйлын шударга, тэнцвэртэй байж, доргио улс төрч бүрт бүгдэд нь адил тэгш хандана гэдгээ хэл. Түүнчлэн тэрхүү доргио улс төрчийн хэлснийг сурвалжлахдаа бусад нэр дэвшигчдийн санал бодлыг оруулахаа мартуузай. Нэр дэвшигчид хэвлэл мэдээллийн анхаарлыг шаардахдаа ихэнхдээ тэнцвэртэй мэдээллийг хүсдэггүй. Хараат бус мэдээ бэлтгэх төлөвлөгөө хийхийг хичээх явцад тэнцвэртэй мэдээлэл чухал юм.

Сонгогчдын дуу хоолойг сонсохын үзэл баримтлыг санаарай. Сонгогчид юун тухай ярьж буйг илэрхийлдэг, тэдний санааг зовоож буй үйлийн тухай өгүүлдэг мэдээний дэг журам нь нэр дэвшигчдийг ч өөрийн эрхгүй эдгээр асуудлын тухай бас ярьж эхлэх итгэл үнэмшил төрүүлэх магадлалтай.

Сонгууль сурвалжлах төлөвлөгөө бэлтгэж байхдаа болгоомжтой хандаарай. Жишээ нь, танай хүн хүч, хөрөнгө мөнгө хязгаарлагдмал бол цөөн хүрээ сонгон авч, хийсэн шиг хийх нь зүйтэй. Энэ нь юм бүхнийг хамруулж, тааруу хийхээс хавьгүй илүү.

Анхаарвал зохих асуулт

Танай тархалт хязгаарлагдмал уу? (Үндэсний, бүсийн, орон нутгийн хэмжээнд үү?) Тодорхой зарим үйл явдал дээр бусад радио, телевиз, сонинтой хамтарвал дээргүй юу? Өргөн нэвтрүүлгийн хэд хэдэн станц, сүлжээ улс төрийн мэтгэлцээн, олон нийтийн уулзалтыг дамжуулах камер, микрофон, дуу, дүрсний нэг багц ашиглан хамтарвал хямд төсөр биш үү? Бусад станц, сонинтой түншлэх нь хөрөнгө мөнгө хэмнэхээс гадна хараат бус байдлаа хадгалах боломж олгоно. Санал хураалтын тооллогын үр дүнг сурвалжлахдаа хамтран ажиллах боломжтой. Энэ нь олон оронд нийтлэг туршлага байдаг. Энэ нь сонсогч бүр, уншигч бүр адил мэдээлэл авахад нэмэртэй. Радио, телевиз, сонин, интернэт хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүр сонгуулийн үр дүнг тайлбарлах, таниулахад өөрийн редакцийн хараат бус байдлыг хадгалах болно.

Сонгуулийн төлөвлөгөөгүй бол та олон нийтэд сайн, ойлгомжтой, тэнцвэртэй мэдээллээр үйлчлэхийн оронд зөвхөн үйл явдалд хөтлөгдөн, түүнд хариу өгөх болно.

Сонгуулийн сурвалжлага

Төлөвлөгөөгүй бол:

Та доорхи үйл явдлыг сурвалжлах төлөвтэй
 Намын үйл явдал
 Нэр дэвшигчийн бодлого, хөтөлбөр
 Хэн тэргүүлж байна? (Морины уралдаан)
 Намын стратеги
 Удирдлага нь юу хэлж буйг
 Намын алдар хүнд
 Намын өнгөрсөн амьдрал

Төлөвлөгөөтэй бол:

Таны сурвалжлагын төлөв байдал
 Намын мөрийн хөтөлбөрт дүгнэлт хийх
 Иргэдийн асуултад хариулна
 Дагуулах эрсдлийг олж мэдэх
 Санал болгож буй шийдвэрийн тухай мэдээлнэ
 Өөрийн эрэн сурвалжлага хийх
 Намын ур чадварын тухай мэдээлнэ
 Намын өнөөгийн үйлдлийн тухай мэдээлнэ

Сонгууль сурвалжлах төлөвлөгөө зохиох нь

Гурван үе шат: Кампанит ажлын өмнө, дунд, дараа

Кампанит ажлын өнгөрсөн сонгуулийн үеэр хэн ямар намд байсан, нам бүр хэдэн нэр дэвшигчтэй байсан гэх мэт тоо баримтыг цуглуулах нь чухал. Түүнчлэн, нэр дэвшигч бүр, сонгуулийн тойрог бүр, өрсөлдөгч бүрийн тухай суурь мэдээлэл цуглуулна. Энэ баримтжуулалтыг судалгаа, хэвлэлийн мэдээ, сонин, интернэтийн мэдээллээр байнга баяжуулж, кампанит ажлын гурван үе шат бүхэнд ашиглана.

Сонгуулийн сурвалжлагын төлөвлөгөө хийх тогтсон жор байхгүй. Гэхдээ түүнийг бэлтгэх нь сонгуулийг сайн сурвалжлахад хамгийн чухал хэсэг юм.

Нээлттэй сэтгэлгээгээр эхэл: Баримтжуулалттай бол. Үүнд сонгуулийн хууль, бүх нам, нэр дэвшигчдийн нэр, холбоо барих хаяг, олон нийтийн санал асуулгын товчоо, байгууллага байвал тэдний хаяг, холбоо, сонины өгүүлэл, нийтлэл, интернэтийн судалгаа, зарцуулахаар зөвшөөрөгдсөн хөрөнгө мөнгөний хэмжээний тухай мэдээлэл багтана.

Бүх нам руу утасдаж, тэдний сонгуулийн хуанлийг олж ав: Намууд үйл явдлыг урьдчилан төлөвлөдөг. Тэр тухай та мэдэхийг хүсэж байгаа. Сонгуулийн штаб, санал хураах байрны тухай мэдээлэл цуглуул.

Мэргэжилтнүүдийн жагсаалттай бол: Үүнд тайлбарлагч, тоймч, улс төрөөр мэргэшсэн эрдэмтэд, кампанит ажлын үеэр дурьдагдаж болзошгүй асуудлаар мэдлэг бүхий мэргэжилтнүүд орно. Эдгээр хүмүүсийн зарим нь кампанит ажлын үеэр болон дараа нь сурвалжлагад үнэлж баршгүй хувь нэмэр оруулах болно.

Байр бэлтгэ: Редакцдаа сонгуулийн талаар цуглуулсан бүх материалаа тавьж, санал солилцох, хэлэлцэх газартай бол.

Улс төрийн намуудын бодлоор хэвлэл мэдээлэлгүйгээр тэд оршихгүй. “Сайн, муу хэлэх нь хамаагүй. Гагцхүү ярьж байх л ёстой!” гэдэгтэй адил. Гэхдээ сэтгүүлчид намын мэдэгдэл, үйл явдал жинхэнэ үү, эсвэл хэвлэл мэдээлэл, олон нийтийн анхаарлыг хандуулахын тулд бий болгосон уу гэдгийг олж тогтоох ёстой.

Сэтгүүлчийн хувьд, жирийн сонгогчдын нэрийн өмнөөс тухайн нам энэ амлалтаа хэрхэн, ямар байдлаар хэрэгжүүлэх тухай тодорхой асуулт тавих ёстой гэдгээ умартаж болохгүй. Эсрэг санал өгсөн байхад чухам яагаад энэ санааг яагаад дэмжиж байгаа тухай илэрхий мэт асуултыг ч тавь. Яагаад, юун тухай, хэрхэн гэж эхлэх нээлттэй төгсгөл бүхий асуулт тавихаа мартуузай. Эдгээр нь улс төрчдийг асуултад бүрэн хариулахыг шаарддаг.

Олон нийт санал хураалтын үед мэдээлэлтэй сонголт хийхэд туслахын тулд бүх намын тухай шударга, нэр төртэй мэдээлбэл зохино. Ерөнхийдөө энэ нь нам бүрт адил тэнцүү цаг зориулна гэсэн үг юм.

Олон нийтийн санал асуулга бол тухайн үедээ улс төрийн нэр хүнд хэр байгааг хэмжих

нэг арга юм. Хэрэв тухайн санал асуулгад найдаж тулгуурлаж болмооргүй санагдвал редакцийнхаа нөхдөөс долоо хоногт нэг удаа 5 эсвэл 10 нэр хүнд бүхий нэр дэвшигчийг нэрлэхийг хүсэж болно. Нэг хүний жагсаалтад нэгээс гурван нэр дэвшигчийн нэр бичигдсэн байх магадлал өндөр байдаг. Энэ нь тухайн долоо хоногт ямар нэр дэвшигчид анхаарал хандуулах талаар сайхан санаа өгнө. Кампанит ажил эрчимжихийн хэрээр зарим нэр дэвшигчийн хувь чанар, түүний санаа бусдаас илүү таны анхаарлыг татах болно. Иймд жагсаалт өөрчлөгдөж болзошгүй. Рейтинг нь өндөр бус байгаа нэр дэвшигчдийг ч мөн сурвалжилж, тэдний хөндөж буй асуудлыг тэргүүлж буй нэр дэвшигчийнхтэй харьцуулах нь мөн чухал юм. Танай жагсаалтад рейтинг доогуур байгаа нам, нэр дэвшигч олны нүдэн дээр нэр хүнд нь өссөн бол та уян хатан байж, зохих түвшинд мэдээлэх ёстой.

5. Практик мэдээлэл

Харилцаа холбоо

Та цаг ямагт найдвартай харилцаа холбоотой байх ёстой. Дэлхий дээр ашиглаж буй гар утасны ихэнх нь GSM технологи хэрэглэдэг. Олон улсын роамингийн үйлчилгээний үнэ тарифаас орон нутгийн сим карт ашиглах нь хамаагүй хямд. Ихэнх тохиолдолд тухайн орон нутагт ирж буй дуудлага үнэ төлбөргүй байдаг. Орон нутгийн карт мөн шаардлагатай тохиолдолд нэмэлт нэгжийн багцтай байдаг юм.

Хэрэв та өндөр хурдны интернет ашиглах боломжтой бол www.skype.com лаптопоосоо маш бага үнээр ярих программтай. Үүнийг хувийн хэрэгцээнд ашиглаж болно. Гэхдээ гар утсыг орлохгүй.

Тээвэр

Эх орноосоо явахын өмнө унаа тээврийг чинь хэн хариуцаж буйг мэдэж ав. Нисэх буудлаас ирж, очих унаа гэсэн үг. Такси байх уу, эсвэл байгууллага чинь унаа хөлсөлж байгаа юу? Өөрийг чинь хүн тосох уу? Сум нэвтэрдэггүй унаа хэрэгтэй юу? Хамгаалалт шаардлагатай юу? Аливаа зөрчилдөөнөөс зайлсхийхийн тулд тусгай маршрутаар явах ёстой юу? Энэ бүхнийг аян замд гарахаасаа өмнө заавал нягтлан шалгаарай.

Мэдээлэл

Дараахь мэдээлийг өөрийн тэмдэглэлийн дэвтэр, гар утас, лаптопдоо бичиж хадгал. Аль нэгийг нь алдлаа гэхэд чухал мэдээлэл чинь аль нэгэнд нь үлдэх болно.

- Багийн бүх гишүүд, зохион байгуулагчдын гар утасны дугаар
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэргэжлийн байгууллагуудын холбоо барих хаяг, утас.
- Засгийн газрын гол байгууллага, яамдын (Харилцаа холбоо, харуул хамгаалалт, боловсрол, эсвэл зам тээврийн байгууллага) холбоо барих хаяг, утас.
- Сонгуулийн хороо, зөвлөл, улс төрийн намууд, гол нэр дэвшигчид
- Голлох үүрэг бүхий төрийн бус байгууллага, хүний эрх, эмэгтэйчүүдийн бүлгүүд
- Цагдаагийн байгууллага (байдаг бол НҮБ-ын төлөөлөл)
- Орон нутгийн такси үйлчилгээ
- Орон нутгийн эмнэлэг, эмийн сан, эмч, шүдний эмч
- Гол элчин сайдын яамд, консул
- Орон нутгийн сүм хийд. Шашин дэлгэрүүлэгчид. Тэд бол тухайн орны нөхцөл байдлын тухай мэдээллийн үнэлж баршгүй эх сурвалж
- “Сэтгүүлчдийг хамгаалах хороо” (Committee to Protect Journalists), “Хил хязгааргүй сурвалжлагчид” (Reporters without Borders), “Олон улсын сэтгүүлчдийн холбоо” (international Federation of Journalists). Эдгээр байгууллага аюул бэрхшээл тулгарсан сэтгүүлчдэд тусламж үзүүлдэг.

Аюулгүй байдал, хамгаалалтын тухай дэлгэрэнгүй мэдээлэл, тухайлбал тухайн оронтой холбоотой сэрэмжлүүлгийг “Олон улсын мэдээний аюулгүй байдлын хүрээлэн” (International News Safety Institute- INSI)-гийн www.newssafety.com цахим

хуудаснаас авч болно. Мөн аюулгүй байдлаа хангах зарчмын тухай www.newssafety.com/safety/index.htm хуудаснаас уншаарай. Түүнчлэн ЮНЕСКО, “Хил хязгааргүй сурвалжлагчид” байгууллагаас эрхлэн гаргасан “Сэтгүүлчдэд зориулсан практик зөвлөмж” хэмээх чухал гарын авлагыг www.researchdamocles.org/IMG/pdf/GUIDE_Anglais_2002.pdf цахим хуудаснаас авч болно.

Тогтмол хэлхээ холбоо

Шинэчлэгдсэн мэдээллээс илүү чухал зүйл байхгүй. Багийнхаа нөхөдтэй байнга ярилц. Мэдээлэл солилц. Зааварчилгааны зөвлөгөөнөөс юу нь болж байна, юу нь болохгүй байгаа тухай, аюулгүй байдлын нөхцөл, орон нутгийн хандлага гэх мэтийн тухай ярилц. Өөрт байгаа мэдээллээ хуваалцах нь чухал шүү.

Мэдээлэлтэй бай.

- Мэдээ сонсож, өөрийн ажлыг үнэлэхийн тулд зөөврийн авсаархан радио авч яв
- Орон нутгийн сонинг тогтмол уншиж, телевиз байнга үз
- Орон нутгийн болон олон улсын мэдээний цахим хуудсыг тогтмол үз.
 - Олон улсын: www.bbc.co.uk
 - Дэлхийн мэдээний сүлжээ: www.wnEurope.com
 - Африк: www.irinnews.org, www.allafrica.com, www.westafricanews.com, www.afrol.com
 - Ойрхи Дорнод: www.mideastweb.org
 - Ази: www.asianewsnet.com
 - Кавказ: www.caucastimes.com
 - Латин Америк: www.ipsnews.net/latin

Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө

Зааварлагчид ихэнхдээ улс төрийн байдал нь тогтвор муутай улс оронд ажиллах томилолт авдаг. Нөхцөл байдал аюултай байж болзошгүй. Иймд анхааруулга сэрэмжлүүлэг чухал юм.

- Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөтэй бай. Онц байдлын үед юу хийхээ багийн гишүүн бүр мэддэг байх ёстой. Бослого тэмцэл, өндөржүүлсэн бэлэн байдал, бусад үйл явдлын үед хэнтэй холбоо барьж, ямар дүрэм журам дагах, шаардлагатай тохиолдолд хэзээ, хаана уулзахаа мэддэг байх ёстой.
- Биедээ байнга газрын зурагтай явж, байнга харж бай
- Ямар газрыг тойрч явахаа мэдэж бай
- Ганцаараа бүү яв, бас байнга дохио өгч бай
- Такси, бусад тээврийн зогсоол, мөн онгоцны буудлуудыг мэдэж бай
- Биедээ хувийн бичиг баримт, бэлэн мөнгөтэй бай
- Санаандгүй зүйл болно гэдэгт бэлэн бай

Биеэ авч явах:

- Бусдыг хүндэтгэж, найрсаг бай

- Нутгийн зан заншилд суралц
- Бусдын анхаарлыг өөртөө төвлөрүүлэх хэрэггүй
- Улс төрийн нам, бүлэглэлтэй холбоотой гэж хардахаар энгэрийн зүүлт, тэмдэг, дарцаг бүү хэрэглэ
- Цагдаа, улс төрийн намын гишүүдтэй хамт бүү яв
- Цаг ямагт нөхөрсөг, төвийг сахиж яв

6. Эх сурвалж: Интернэтээс хэрэгтэй зүйлээ олох нь

Зөвлөгөө ав

Интернэт газар бүрт харилцан адилгүй. Эрх баригчид нь аль хэр хяналт тавьдагаас хамааран та хэрэгтэй зүйлээ олж авч чадахгүй байж мэднэ. Саяхан Хятадад Yahoo болон Google-ийн хийсэн тохиролцоог бусад улс оронд анзаарсан. Интернэтэд орж болох ч мэдээллийн чөлөөт урсгал хязгаарлагдмал байж болно.

- Интернэт байнга хувьсан өөрчлөгдөж байна. Өнөөдөр байгааг өчигдөр байсан, эсвэл маргааш ч байж болно гэхийн аргагүй.
- Олсон зүйл чинь нягт нямбай гэдгийг юу ч батлахгүй. Сонссон, эсвэл уншсан, ялангуяа албан ёсны мэт харагдавч танил бус цахим хуудсанд итгэхийн хэрэггүй.

Хайлтын ямар систем, ямар лавлах хэрэглэх вэ?

Дэлхий нийтээрээ www.google.com - ыг хэрэглэх нь их байна. Гэсэн хэдий ч хайлтын бүх системийг ашиглаж хэвшвэл зүгээр. Учир нь хайлтын систем бүр ижилхэн ажиллаж, адилхан үр дүн өгдөггүй.

Сэдвийн лавлах, ангилсан каталогийн жагсаалт

www.yahoo.com, www.excite.com, www.beaucoup.com – г дараахь тохиолдолд ашиглаарай:

- Өргөн сэдэв, санаа хайхаар бол
- Өөрийн хүссэн сэдвээр ганц нэг цахим хуудас биш, жагсаалт нь хэрэгтэй бол

Нарийвчилсан хайлтын

www.altavista.com, www.google.com, www.hotbot.com - г дараахь тохиолдолд ашиглаарай.

- Тусгай баримт сэлт, хүн, үйл явдал, сэдэв хайх, эсвэл тухайн сэдвээр хэд хэдэн санаа агуулж буй бол
- Эдгээр цахим хуудас мөн тусгай анкет бөглөж, гүнзгий хайлт хийх боломж олгодог

Хайлтын зарим систем англиар энгийн асуулт тавихад илэрц олддог.

www.altavista.com, www.google.com, www.yahoo.com, www.dogpile.com, www.brainboost.com.

Бусад хэл дээр ч хайлт хийх боломжтой

www.msn.com, www.altavista.com, www.google.com, www.yahoo.com.

Практик зөвлөмж:

- Юу хүсэж буйгаа мэд. Олон тоон дээр биш ганц тоон дээр үгээ бич. Түлхүүр үгийн адил төстэй хэд хэдэн хувилбарыг турш
- Нийтлэг, ерөнхий үгийг онцгойлсон нэр томъёо ашиглахгүйгээр бүү хэрэглэ. Жишээ нь, нам гэдэг хэтэрхий ерөнхий учир улс төрийн нам, намын бодлого, эсвэл ардчилсан нэмэх нь улсын нэр гэж хайсан нь дээр.
- Яг тодорхой өгүүлбэрээр хайх бол “Ардчилсан нам” гэж хашилтад бич. Хашилтгүй тохиолдолд аль нэг бичвэр орсон ардчилсан нам гэсэн бүхэн гарч ирнэ

- Хайж буй мэдээлэлдээ түлхүүр үгээ оруулах. Ингэхдээ нэмэх тэмдэг тавих, эсвэл AND гэж бичих. Жишээлбэл, нам + ардчилал
- Хайж буй нэр томъёогоо тусгаарлахын тулд хасах тэмдэг, эсвэл нэр томъёоныхоо яг өмнө NOT гэж бичээрэй. Жишээ нь, Эйнштейн - харьцангуйн онол, эсвэл Einstein NOT харьцангуйн онол

Тайлбар: Интернэтийн хайлтын тухай 140 хуудас бүхий ЮНЕСКО-гийн гарын авлагыг үзье гэвэл [google-ээс](#) “The NET for journalists” гэж хайгаарай.

Сонгуультай холбоотой цахим хуудас

Хангалттай хайлт хийвэл Web-ээс бараг бүх нарийвчилсан мэдээллийн багцыг олж чадна. Сонгууль сурвалжлах тухай зааварлагчдад ашигтай мэдээлэл авч болох зарим цахим хуудсыг дор нэрлэв. Үүнд:

“Ардчилсан сонгуультай холбоотой чухал мэдээллийн бүрэн лавлах”, “Ардчилал, сонгуулийн туслалцааны хүрээлэн”-гийн www.aceproject.org цахим хуудаст бий

“Сонгуулийн тогтолцооны олон улсын сан”: www.ifes.org/

“Сонгуулийн кампанит ажлын үеэр хэвлэл мэдээллийн шударга байдалд хийх мониторинг”, Патрик Мерло (Patrick Merloe. Washington DC, NDI: Tacis, 1995)

“Сонгууль сурвалжлах сургалтын төслийн тайлан, олон улсын хэвлэл мэдээллийн хөгжлийн байгууллага”, Internews: www.internews.org/activities/elections/default.htm

“Сонгууль, хэвлэл мэдээллийн асуудлаарх ЮНЕСКО-гийн хөтөч”, “19-р зүйл (Article 19)” Иракийн сонгуулийн тухай нийтлэлд тулгуурласан. Гэхдээ өргөн хүрээнд ашиглаж болно. portal.unesco.org

“Олон улсын сэтгүүлчдийн холбоо”-ны сонгууль сурвалжлах гарын авлага www.ifj.org/pdfs/electionreporting.pdf

“Хэвлэл мэдээлэл ба сонгууль: Сонгууль сурвалжлах гарын авлага” www.impacs.org

7. Редакцийн сануулга: Энэ хуудсыг редакцдаа өлгөөрэй.

Сонгууль сурвалжлах нь: Миний түүх бүрэн гүйцэд үү?

Сэтгүүлч, редактор бүр сонгуулийн мэдээ сурвалжлагыг гаргахаасаа өмнө өөрөөсөө асуух нь зүйтэй.

1. Энэ түүх нягт нямбай юу? Баримт сэлт, нэр ус нь зөв үү? Энэ мэдээлэл үнэн гэдэгт би итгэж байгаа юу?
2. Энэ түүх алдаа мадаггүй, шударга, тэнцвэртэй юу? Энэ нь хоёр талыг хамарсан, эсвэл өөр санаа бодлыг тусгасан уу? Аль нэг нам, нэр дэвшигчид илүү хандаагүй биз?
3. Энэ нь хариуцлагатай сэтгүүл зүйн зарчимд нийцэж байгаа юу? Мэдээлэл олж авахын тулд хээл хахууль өгсөн, эсвэл хууль бус арга хэрэглээгүй биз? Эх сурвалжаа хамгаалсан уу, сонгуулийн болон хэвлэл мэдээллийн хууль зөрчөөгүй биз?
4. Энэ түүх сонгогчдод зориулагдсан уу? Сонгогчдод зориулсан чухал мэдээлэл агуулсан уу? Сонгогчдын сэтгэл зовоож буй зүйлийг тусгасан уу?
5. Энэ нь бүрэн дүр зураг уу? Хэрэглэсэн үг, гэрэл зураг, телевизийн клип, дуу бичлэг тухайн үйл явдал дээр болсон хамгийн чухал зүйлийн дүр зургийг илтгэж байгаа юу?
6. Сонгогчдыг өөрийн ашиг сонирхлын төлөө ухаалаг санал өгөхөд нь туслахуйц сайн мэдээллээр хангаж байгаа юу?
7. Энэ сонгууль чөлөөтэй, шударга явагдаж байна уу? Энэ сонгуулийн тухай сурвалжлагаар өөр мэдээлэл байгаа юу?

Хэвлэл мэдээлэл ба сонгууль, Росс Хорвардын “Сонгууль сурвалжлах гарын авлага”-аас. An Elections Reporting (Handbook. By Ross Howard. IMS-IMPACS. 2004)

8. Зааварлагчдад зориулсан асуулга

Гарын авлагыг боловсруулсан баг таныг уг гарын авлагыг хэрхэн ашигласан тухай мэдэх хүсэлтэй байдаг. Иймээс та доорх асуултад хариулж, International Media Support байгууллагын хаягаар илгээнэ үү. (Хаягийг хоёрдугаар нүүрнээс харна уу.)

1. Хувиараа, эсвэл байгууллагын хувьд хаана, хэдийд зааварчилгааны арга зүйг ашигласан бэ? Зааварчилгааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, хэдэн хүн хамарсан бэ? Өөрийн нэр, хаягийг бичнэ үү.
2. Хувиараа, эсвэл байгууллагын хувьд гарын авлагыг ямар давтамжтай ашигласан бэ? Тогтмол, өдөр бүр, долоо хоногт нэг удаа, тодорхой хуваарьгүйгээр хэд хэдэн удаа, эсвэл огт хуваарьгүй юу?
3. Гарын авлагын аль хэсэг хамгийн ашигтай байсан бэ?
4. Танилцуулга, арга зүй, сонгууль сурвалжлах ба суурь сэтгүүл зүйн багц зэргийн аль хэсэг илүү ашигтай байсныг тайлбарлана уу.
5. Аль хэсгийг нь хувилж, оролцогчдод тараасан бэ?
6. Гол ач холбогдол бүхий ямар сэдэв энэ гарын авлагад тусгагдаагүй вэ? Үүнийг та хэрхэн нөхсөн бэ?
7. Гарын авлагын шинэчилсэн хувилбар хийвэл ямар нэмэлт материал оруулахыг зөвлөх вэ?